



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ  
2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГО

# ӨНДӨР НАСТАН

Улаанбаатар хот  
2021 он

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,  
Засгийн газрын III байр  
<http://www.nso.mn>  
И-мэйл: [information@nso.mn](mailto:information@nso.mn)

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж  
боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

ISBN: 978-99929-64-74-X

## АГУУЛГА

ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД .....	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	7
УДИРТГАЛ .....	8
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.....	9
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, БҮТЭЦ, АГУУЛГА	
ХОЁРДУГААР БҮЛЭГ .....	21
ӨНДӨР НАСТНЫ ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ	
ГУРАВДУГААР БҮЛЭГ .....	31
ӨНДӨР НАСТНЫ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, СУУЦНЫ НӨХЦӨЛ	
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ .....	477
ӨНДӨР НАСТНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	67
ХАВСРАЛТ.....	72

## ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

### НЭГ. ХЯНАСАН

Авирмэдийн Амарбал

Эдийн засагч-Хүн ам зүйч, Хүн ам зүйн ухааны доктор  
ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга, Хүн ам, орон  
сууцны тооллогын Улсын комиссын нарийн бичгийн дарга

Төмөрбаатарын Болор-Эрдэнэ

Эдийн засагч-Хүн ам зүйч  
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга

### ХОЁР. БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

Пандийн Бямбацэрэн

Эдийн засгийн ухааны доктор, профессор  
Монголын ахмадын Холбооны дэд ерөнхийлөгч

Юмсүрэнгийн Туул

Эдийн засгийн ухааны доктор  
Этүгэн их сургуулийн тэнхимийн эрхлэгч, Монголын ахмадын Холбооны  
ахмад эрдэмтэн зөвлөхүүдийн зөвлөлийн гишүүн

Даваахишигтийн Төрбат

Программист, санхүүч туслах судлаач

### ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

Төгсбатын Ариунсайхан

Эдийн засагч  
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны статистикч

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 2. 1. ӨНДӨР НАСТНЫ ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, 1956-2020 ОН .....	22
ХҮСНЭГТ 2. 2. ӨНДӨР НАСТНЫ ТОО, ӨСӨЛТ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 1989, 2000, 2010, 2020 ОН .....	23
ХҮСНЭГТ 2. 3. ӨНДӨР НАСТНЫ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010, 2020 ОН .....	24
ХҮСНЭГТ 2. 4. ӨНДӨР НАСТНЫ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН .....	25
ХҮСНЭГТ 2. 5. ӨНДӨР НАСТНЫ ХҮН АМ ЗҮЙН ҮНДСЭН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 1989, 2000, 2010, 2020 ОН .....	26
ХҮСНЭГТ 2. 6. ӨНДӨР НАСТНЫ ТОО, ХОТ, ХӨДӨӨ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН .....	28
ХҮСНЭГТ 2. 7. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, 2000, 2010, 2020 ОН.....	29
ХҮСНЭГТ 2. 8. ӨНДӨР НАСТНЫ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДАЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН .....	29
ХҮСНЭГТ 2. 9. ШИЛЖИН ИРСЭН ӨНДӨР НАСТАН, НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН .....	30
ХҮСНЭГТ 3. 1. НИЙТ ХҮН АМЫН БОЛОН ӨНДӨР НАСТНЫ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН .....	32
ХҮСНЭГТ 3. 2. ӨНДӨР НАСТНЫ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН .....	33
ХҮСНЭГТ 3. 3. ӨНДӨР НАСТАН ӨРХ, ӨРХӨД ТООЛОГДСОН ХҮНИЙ ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	36
ХҮСНЭГТ 3. 4. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАНТАЙ ӨРХИЙН ТОО, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ӨМЧ, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН .....	39
ХҮСНЭГТ 3. 5. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН ТОО, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ӨМЧ, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН.....	40
ХҮСНЭГТ 3. 6. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХ, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР, 2010, 2020 ОН .....	41
ХҮСНЭГТ 3. 7. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН.....	43
ХҮСНЭГТ 3. 8. ӨНДӨР НАСТАН ГИШҮҮНТЭЙ, БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ХООЛ УНДАА БОЛГОДОГ ТҮЛШНИЙ ТӨРӨЛ, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН .....	44
ХҮСНЭГТ 3. 9. ГЭРТ АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТНЫ ӨРХИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТООГООР, 2010, 2020.....	45
ХҮСНЭГТ 3. 10. ГЭРТ АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ӨРХИЙН АХУЙН НӨХЦЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН .....	45
ХҮСНЭГТ 4. 1. НИЙТ ХҮН АМ, ӨНДӨР НАСТАН ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, ҮНДЭС, УГСАА, ХҮЙСЭЭР, 2000, 2010, 2020 ОН.....	48
ХҮСНЭГТ 4. 2. ӨНДӨР НАСТНЫ ҮНДЭС, УГСАА, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН.....	49
ХҮСНЭГТ 4. 3. ӨНДӨР НАСТНЫ ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	49
ХҮСНЭГТ 4. 4. ӨНДӨР НАСТНЫ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	50
ХҮСНЭГТ 4. 5. ӨНДӨР НАСТНЫ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН.....	51
ХҮСНЭГТ 4. 6. ӨНДӨР НАСТНЫ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН .....	53

ХҮСНЭГТ 4. 7. ӨНДӨР НАСТНЫ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН .....	54
ХҮСНЭГТ 4. 8. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ӨНДӨР НАСТАН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН.....	55
ХҮСНЭГТ 4. 9. АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ӨНДӨР НАСТАН, АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН .....	56
ХҮСНЭГТ 4. 10. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ӨНДӨР НАСТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ (СТАТУС), НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН .....	57
ХҮСНЭГТ 4. 11. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ӨНДӨР НАСТНЫ ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН .....	58
ХҮСНЭГТ 4. 12. ТЭТГЭВЭР АВЧ БАЙГАА ӨНДӨР НАСТЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН .....	60
ХҮСНЭГТ 4. 13. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ӨНДӨР НАСТНЫ ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН .....	61
ХҮСНЭГТ 4. 14. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ӨНДӨР НАСТНЫ ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН .....	61
ХҮСНЭГТ 4. 15. ОЛДМОЛ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ӨНДӨР НАСТНЫ ТОО, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН.....	63
ХҮСНЭГТ 4. 16. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ӨНДӨР НАСТНЫ ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН.....	64

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 2. 1. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2000, 2010, 2020 ОН.....	23
ЗУРАГ 2. 2. ӨНДӨР НАСТНЫ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, 2000, 2010, 2020 ОН ..	26
ЗУРАГ 2. 3. ӨНДӨР НАСТНЫ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН .....	27
ЗУРАГ 2. 4. НИЙТ ХҮН АМД 0-14, 60, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН .....	28
ЗУРАГ 3. 1. НИЙТ ӨНДӨР НАСТАНД БЭЛЭВСЭН ӨНДӨР НАСТНЫ ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН .....	33
ЗУРАГ 3. 2. ӨНДӨР НАСТНЫ ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН .....	35
ЗУРАГ 3. 3. ӨНДӨР НАСТАН ӨРХ, ӨРХӨД ТООЛОГДСОН ХҮНИЙ ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН .....	37
ЗУРАГ 3. 4. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН .....	38
ЗУРАГ 3. 5. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАНТАЙ ӨРХИЙН ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, 2020 ОН .....	42
ЗУРАГ 4. 1. ӨНДӨР НАСТНЫ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН .....	48
ЗУРАГ 4. 2. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ӨНДӨР НАСТНЫ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН.....	59
ЗУРАГ 4. 3. ХӨГЖЛИЙН ТӨРӨЛХИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ӨНДӨР НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН.....	62
ЗУРАГ 4. 4. 60, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ СУУРИН ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙС, НАСНЫ БҮЛЭГ, 2020 ОН .....	65
ЗУРАГ 4. 5. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭДЭГ ӨНДӨР НАСТАН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, ХУВИАР, 2020 ОН .....	65

## УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлаас баталсан Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод “Ахмад настны суралцах, хөгжил нөхцөл, боломжийг бүрдүүлэн дэмжиж, шинэ техник, технологи эзэмшин ашиглах, өөрийн мэдлэг, ажлын туршлага, ур чадвараа залуу үедээ өвлүүлэхийг дэмжих, ахмад настанд зориулсан нийгмийн суурь үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, ахмад настан бүрийг тэтгэвэр, орлогын баталгаагаар хангах оновчтой болгох бодлого баримтлана”<sup>1</sup> хэмээн дэвшүүлсэн олон зорилтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах, үнэлгээ хийх улмаар эдгээр цаашид боловсронгуй болгон сайжруулахад “Өндөр настан” сэдэвчилсэн судалгаанд тусгагдсан мэдээлэлүүд нэн чухал ач холбогдолтой байдаг билээ.

Өндөр настны нийгмийн асуудал, ахуй нөхцөл, аж байдлыг сайжруулах, тэдний эрүүл мэнд, халамж, асрамж, сувилгаа, ажил амралтын онцгой нөхцлийг бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төр засаг, олон нийт, төрийн бус байгууллагын бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачдад, өндөр настны тоо, нас, хүйсийн бүтэц, байршил, боловсрол, бичиг үсгийн мэдлэг, хөдөлмөр эрхлэлт, өндөр настны өрх, гэр бүлийн байдал, сууцны нөхцөл, аж байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүргэхэд энэхүү сэдэвчилсэн судалгааны зорилго оршиж байгаа болно.

Өндөр настны өндөр мэдлэг, чадвар, оюуны их нөөц, чадавх, мэргэшлийн ур чадвар, амьдралын арвин баялаг туршлагыг улс, нийгмийн хөгжил, дэвшилд зохистой ашиглан нийгэм, байгууллага хамт олон, өрх, гэр бүлийн түвшинд хүртэл шийдвэр гаргах үйл хэрэгт тэдний оролцоог хангаж, ахмад болон залуу хойч үеийнхний үе хоорондын амьд холбоо, хамтын ажиллагааг бүх талаар бэхжүүлэхэд энэхүү сэдэвчилсэн судалгааны үр дүнд тулгуурлан хөндлөнгийн судлаачдын хийсэн үнэлгээ, дүгнэлт, дэвшүүлсэн санал санаачлага, зөвлөмжүүд чухал түлхэц үзүүлнэ гэдэгт итгэл төгс байна.

Энэхүү сэдэвчилсэн судалгаа нь Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр гарсан өндөр настанд хамаарах дэлгэрэнгүй мэдээллийг өмнөх тооллогуудын дүнтэй харгалзах үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэн дүн шинжилгээ хийхэд боломж олгохоос гадна ахмад настнуудад тулгардаг хөгжлийн бэрхшээлийн байдал болон интернэт орчин, гар утас хэрэглээний холбогдол бүхий шинэ мэдээллийг нэмж оруулснаараа онцлогтой юм.

---

<sup>1</sup> Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, 2016-2025 он



1

БҮЛЭГ

# СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, БҮТЭЦ, АГУУЛГА

## 1.1. СУДАЛГААНЫ БҮТЭЦ, АГУУЛГА

Сэдэвчилсэн судалгаа үндсэн дөрвөн бүлэг, дүгнэлт, зөвлөмж, хавсралтаас бүрдэнэ.

- Нэгдүгээр бүлэгт судалгааны зорилго, үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолт, агуулга, бүтцийг тусгав.
- Хоёрдугаар бүлэгт өндөр настны тоо, өсөлт, бүтэц бүрэлдэхүүний ерөнхий дүр зураг, насжилтын индекс, хүн ам зүйн ачаалал зэргийг хамруулав.
- Гуравдугаар бүлэгт өндөр настны гэр бүлийн байдал, өрхийн хэлбэр, сууцны төрөл, нөхцөл, цахилгаан, ундны усны хангамж, дулаан, түлшний хэрэглээ, цахилгаан эрчим хүчний эх үүсвэр зэрэг ахуйн нөхцөл байдлын үзүүлэлтийг тусгав.
- Дөрөвдүгээр бүлэгт өндөр настны нийгэм, эдийн засгийн байдал, үндэс угсаа, бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжил, боловсролын түвшин, түүнийг хэрхэн ашиглаж байгаа байдал, хөгжлийн бэрхшээлтэй өндөр настан, гар утас болон интернэтийн хэрэглээний ерөнхий дүр зургийг гарган харуулав.

Судалгааны төгсгөлд дүгнэлт, бодлогын зөвлөмжийг оруулав. Мөн өндөр настан судалгааны голлох үзүүлэлтүүдийг аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр боловсруулж хавсаргав.

## 1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол Улсын өндөр настан иргэдийн хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, эдийн засгийн байдал, орон сууцны нөхцөл байдалд сүүлийн 10-20 жилд гарсан өөрчлөлт, тэдгээрт нөлөөлсөн нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг улсын хэмжээнд болон аймаг, нийслэлийн түвшинд тооцоолон гаргахад энэхүү сэдэвчилсэн судалгааны гол зорилго оршино. Түүнчлэн өндөр настны талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, цаашид баримтлах бодлогын чанартай санал, зөвлөмж боловсруулахад судалгааны бас нэг зорилго чиглэгдэж байгаа болно.

Монгол Улсын өндөр настан иргэдийн ая тухтай тайван амгалан, аюулгүй орчинд амьдрах, эрүүл саруул байж урт наслах, нийгмийн халамж, асрамж үйлчилгээнд адил тэгш хамрагдах, ажил хөдөлмөр эрхлэх, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох бүх талын нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн бодлогыг боловсруулах тулгуур үндэслэл болохуйц мэдээллийн найдвартай эх үүсвэр нь тооллого, судалгаа юм. Энэхүү сэдэвчилсэн судалгаа нь Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнд үндэслэн өндөр настны нийгэм, эдийн засгийн байдлыг илэрхийлсэн нас, хүйсийн бүтэц, гэр бүлийн байдал, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, орон сууцны нөхцөлийн талаарх үзүүлэлтийг өргөн хүрээнд хамруулахыг зорив.

Өндөр настанд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон олон улсын нийтлэг жишгийг харгалзан 65, түүнээс дээш настай хүнийг хамруулах шаардлагатай ч өмнөх тооллогын үр дүнтэй зэрэгцүүлэн дүн шинжилгээ хийх зорилгоор энэхүү сэдэвчилсэн судалгааны тайланд 60, түүнээс дээш насны хүн амыг хамруулан авч үзсэн болно.

Сэдэвчилсэн судалгааны хүрээнд тооллогын мэдээлэлд дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийж, өмнөх оны тооллогын холбогдох үзүүлэлттэй харьцуулах, өсөлт, бүтцийг тодорхойлох, тухайн үеийн нийгэм, эдийн засгийн бодлого, тэдгээрийн хэрэгжилт, өнөөгийн өндөр настны нийгэм, эдийн засгийн байдлыг үндсэн 30 гаруй үзүүлэлтээр тодорхойлов. Мөн өндөр настны талаар төр, засгаас явуулсан бодлогын үр дүн, ялангуяа эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, ахуйн нөхцлийг сайжруулах, урт удаан наслах боломж, нөхцлийг бүрдүүлэх чиглэлд цаашид анхаарах тулгамдсан асуудлуудын талаарх санал, зөвлөмжийг уг судалгааны тайланд тодорхой тусгав.

### 1.3. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Өндөр настан сэдэвчилсэн судалгаанд Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод ашигласан дараах үндсэн үзүүлэлтийн нийтлэг ойлголт, тодорхойлолтыг хэрэглэсэн болно.

№	Ойлголт	Тодорхойлолт
<b>ӨРХ, ХҮН АМ</b>		
1	Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.
2	Үндсэн өрх	Сууцны төрөл, хэлбэрээс үл хамааран тухайн сууцыг өмчлөгч өрх, сууц эзэмших эрхийн бичиг /ордер/, орон сууц хөлслөх гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа өрх, өмчлөгч нь өөр этгээд боловч уг сууцанд хамгийн удаан хугацаагаар амьдарч байгаа өрхийг хэлнэ.
3	Хамт суудаг өрх	Тухайн өрхийн өөрийн сууц биш, тухайн сууц эзэмшигчтэй хамт суудаг өрхийг хамруулна.
4	Өрхийн тэргүүлэгч	Ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16, түүнээс дээш настай, хөдөлмөр эрхэлдэг буюу өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн юм.
5	Өрхийн ам бүлийн гишүүд	Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг хэсэг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Гэхдээ тоолох үед тухайн өрх айлд гишүүдээс нь гадна өрхийн ам бүлд хамаарахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно.
6	Ам бүлээрээ байгаа өрх	Ам бүлээрээ байгаа өрх дангаараа амьдрахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эхнэр, нөхөр, хүүхдийн (хүүхдүүдийн) хамт, мөн эцэг эсвэл эх нь хүүхдийн (хүүхдүүдийн) хамт өрх үүсгэн амьдрахыг хэлнэ.

№	Ойлголт	Тодорхойлолт
7	Нийлмэл ам бүлтэй өрх	<p>Нийлмэл өрхөд дараах бүтэцтэй өрх хамрагдана. Үүнд:</p> <p>а. Нэг ам бүл бусад хамаатан садантайгаа хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх</p> <p>б. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл дангаараа хамтран өрх үүсгэн амьдарч байгаа</p> <p>в. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгэнтэй нь хамааралтай хүнтэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа</p> <p>г. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай боловч нэг ам бүлийн биш хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа зэрэг өрх орно.</p>
8	Холимог өрх	<p>Холимог өрхөд дараах бүтэцтэй өрх хамаарна. Үүнд:</p> <p>а. Нэг ам бүл бусад хамаатан садан эсвэл хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх</p> <p>б. Нэг ам бүл, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа өрх</p> <p>в. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгнийх нь хамаатан садан, хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа</p> <p>г. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл эдгээр ам бүлийн алинд ч хамааралгүй хүмүүстэй хамт өрх үүсгэн амьдарч байгаа</p> <p>д. Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралгүй ам бүл бусад хүмүүстэй эсвэл хүмүүсгүйгээр амьдарч байгаа</p> <p>е. Хоорондоо хамааралтай боловч ам бүлийн биш хоёр, түүнээс олон хүмүүс бусад хамааралгүй хүмүүстэй өрх үүсгэн амьдарч байгаа</p> <p>ё. Хоорондоо хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа өрх орно.</p>
9	Оршин суугаа хүн ам	<p>Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга (183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар) оршин суугаа Монгол Улсын харьяат иргэд, гадаадын харьяат болон харьяалалгүй иргэдийг хэлнэ.</p>
10	Бэлэн хүн ам	<p>Тооллого явуулж буй үед тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа нийт хүн амыг (байнга болон түр хугацаагаар амьдарч байгаагаас үл хамаарч) хэлнэ.</p>

№	Ойлголт	Тодорхойлолт
<b>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ</b>		
11	Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг ойлгоно.
12	Төрөлхийн	Удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
13	Олдмол	Ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан.
14	Харааны	Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
15	Ярианы	Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
16	Сонсголын	Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
17	Хөдөлгөөний	Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан.
18	Сэтгэцийн	Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан.
19	Хавсарсан	Хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд тооцно.
20	Бусад	Ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан буюу хязгаарлагдсан.

№	Ойлголт	Тодорхойлолт
<b>БОЛОВСРОЛ</b>		
21	Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгсөөгүй бол <i>Боловсролгүй</i> хүн гэнэ. Мөн 2020 онд ЕБС-ийн 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг <i>Боловсролгүй</i> гэж үзнэ.
22	Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг (1975-1996 он хүртэл), 4 дүгээр ангийг (1975 он хүртэл, 1997-2004 он дуустал), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн
23	Бүрэн бус дунд (суурь) боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг (1975 он хүртэл), 8 дугаар ангийг (1975-2004 оныг дуустал), 9 дүгээр ангийг (2005 он ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн
24	Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10 дугаар ангийг (2005 он дуустал), 11 дүгээр ангийг (2006 он ба түүнээс хойш), 12 дугаар ангийг (2015 ба түүнээс хойш) өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын аттестат ба үнэмлэхтэй хүн
25	Техникийн болон мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн
26	Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн
27	Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг <i>Дээд боловсролтой</i> гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизм оройн дээд сургууль Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

№	Ойлголт	Тодорхойлолт
28	Бичиг үсэг мэддэг	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг <i>Бичиг үсэг мэддэг</i> гэж үзнэ.
29	Бичиг үсэг мэддэггүй	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг <i>Бичиг үсэг мэддэггүй</i> гэнэ.
<b>ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ</b>		
30	Огт гэрлээгүй	Арван тав ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүн
31	Гэрлэсэн батлуулаагүй	Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүн
32	Гэрлэсэн батлуулсан	Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүн
33	Тусгаарласан	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр <i>Тусгаарласан</i> гэж үзнэ. Гэхдээ албан ажлын улмаас 2 тусдаа амьдарч байгаа хүнийг тусгаарласан гэж үзэхгүй.
34	Цуцалсан	Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр <i>Цуцалсан</i> гэж үзнэ.
35	Бэлэвсэн	Эхнэр/нөхрийн аль нэг нь нас барснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр <i>Бэлэвсэн</i> гэж үзнэ.
<b>ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ</b>		
36	Ажил эрхэлдэг хүн	Сүүлийн 7 хоногт наад зах нь 1 цаг цалин хөлстэй хөдөлмөр эрхэлсэн болон ер нь цалинтай ажил/бизнесийн үйл ажиллагаа байгаа хүн ам;
37	Ажилгүй хүн	Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.
38	Хөдөлмөрийн насны хүн ам	15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.



№	Ойлголт	Тодорхойлолт
39	Боломжит ажиллах хүч	<p>Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм (заалт 40с, 51, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна.</p> <p>Үүнд:</p> <p>а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн;</p> <p>б. Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.</p>
40	Ажиллах хүч	<p>Тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.</p>
41	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	<p>Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно.</p>
42	Цалин хөлстэй байнгын ажиллагч	<p>Ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насны дээд хязгаар, тэтгэвэрт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүйгээр хөдөлмөр эрхэлдэг ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно. Мөн ажилд ороод удаагүй, туршилтын хугацаандаа ажиллаж байгаа боловч цаашид үргэлжлүүлээд байнгын хугацаагаар ажиллуулахаар хүлээгдэж байгаа ажиллагч орно.</p>
43	Цалин хөлстэй түр ажиллагч	<p>Хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3 ба түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно.</p>
44	Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	<p>Ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм</p>

№	Ойлголт	Тодорхойлолт
45	Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан	Цалин хөлстэйгөөр, ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй ажиллагч юм.
46	Гүйцэтгэх гэрээлэгч	Эдийн засгийн өөр нэг нэгжид, эсвэл уг нэгжээр дамжуулаад бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор арилжааны шинжтэй гэрээ (хөдөлмөрийн бус) байгуулан ажиллаж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагч нь тухайн эдийн засгийн нэгжийн цалин хөлстэй ажиллагч биш боловч ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэл, орлого болон зах зээлд гарах боломж зэрэг нь уг эдийн засгийн нэгжээс хамаардаг. Мөн эдгээр ажиллагч нь тэдний үйлдвэрлэлийн (бүтээмжтэй) үйл ажиллагаанд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлынх нь үр шимийг шууд хүртдэг эдийн засгийн өөр нэгжээс хараат, ашгийн төлөө ажиллагч юм.
47	Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч	Ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.
48	Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч	Ашиг олох зорилгоор аж ахуй нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуй нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулж байгаа ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

№	Ойлголт	Тодорхойлолт
49	Ажилтан ажиллуулдаггүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч	Ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл хувь эзэмшигч, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж, байгууллагын (хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо) үйл ажиллагааг эрхэлж буй ажилчид юм.
50	Ажилтан ажиллуулдаггүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	Ямар нэгэн цалин хөлстэй ажиллагч авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрхэлж явуулдаг ажилчид юм.
51	Хувь нэмрээ оруюлагч гэр бүлийн гишүүн	Өрхийн гишүүд, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эрхэлж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажилд, эсвэл тэдгээрийн цалинтай ажил болон гүйцэтгэх гэрээлэгчээр ажиллаж буй ажилд нь тусалж байгаа ажиллагчийг хэлнэ. Тэд эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гаргадаггүй, үүрэг хүлээдэггүй бөгөөд цалин хөлсгүйгээр оролцож, үйл ажиллагаанаас олсон орлогоос өрх дотроо ашиг хүртдэг.

### ОРОН СУУЦ

52	Байшин	Байшин гэж нэг болон олон өрөөтэй, дээвэртэй, гадуураа ханатай, сууринаас дээвэр хүртэл ханаар хуваагдсан талбай бүхий орон байрыг хэлнэ. Байшинд орон сууцны байшин, бие даасан тохилог сууц (хаус), сууцны тусдаа байшин (гэр хорооллын хашаанд барьсан тоосгон, шавар болон модон ханатай сууцны байшин), нийтийн болон нийтийн зориулалтын бусад байр орно.
53	Орон сууцны байшин	Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. Орон сууцны байшин нь дэд бүтцийн бүх төрлийн суурь хангамжаар тоноглогдсон, дараах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна. Үүнд: (а) Цахилгаан, дулааны шугам сүлжээ болон усан хангамжийн сүлжээтэй; (б) Сууцны дотор бие засах газартай; (в) Сууцны дотор байрлуулсан онгоц, шүршүүртэй; (г) Зориулалтын гал тогоо болон хоол хийх талбайтай байна.

№	Ойлголт	Тодорхойлолт
54	Бие даасан тохилог сууц	Нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан, агааржуулалтын систем, ус хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай (ус татдаг) байна. Өрөө тасалгаа нь өөр айлын сууцны өрөө, тасалгааны дээр байрлаагүй, орц, туслах өрөө тасалгаа, дээврийн хөндий, зоорийн давхар, шугам сүлжээний хонгил зэрэг нь нийтийн бус зориулалттай сууцыг үүнд хамруулна. Сууцны өрөө /унтлагын ба зочны/, гал тогоо, ариун цэврийн буюу шүршүүрийн өрөө, бие засах өрөө, агуулах, ханын шүүгээтэй мөн мансардтай болон мансардгүй байж болно.
55	Сууцны тусдаа байшин	Ихэвчлэн гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халалтын систем, ус хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.
56	Нийтийн байр	Нийтийн байр нь ихэвчлэн нийтийн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байдаг. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид, бүх шатны сургуулийн оюутан, сурагчдын дотуур байр, түүнтэй адилтгах бусад нийтийн байрыг хэлнэ.
57	Нийтийн зориулалтын бусад байр	Нийтийн зориулалтын бусад байр гэдэгт амралтын газар, рашаан сувилал, эмнэлэг, асрамжийн газар, шорон, цэргийн хуаран зэрэг хүмүүс бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ суух нийтийн байрыг хамааруулна. Амралтын газар гэж хот, суурин газар болон түүнээс гадагш байрласан, амралт, чөлөөт цаг өнгөрөөх хэрэгслээр тоноглогдсон үзвэр, үйлчилгээ үзүүлдэг цогцолборыг; рашаан сувиллын газар гэж эмчилгээний техник хэрэгслээр тоноглогдсон газрыг ойлгоно. Зочид буудал гэж хот, бусад суурин газарт байрласан зочид, үйлчлүүлэгчдийг хүлээн авч байр, хоолны болон бусад үйлчилгээ үзүүлдэг цогцолборыг; орон сууцны зочид буудал гэж нийтийн орон сууцанд байрласан зочид үйлчлүүлэгчдийг хүлээн авч байр, хоолны болон бусад үйлчилгээ үзүүлдэг газрыг ; түр хоноглох байр гэж авто буудал, дэн буудлын болон түүнтэй төстэй бусад үйл ажиллагаа явуулдаг газрыг тус тус ойлгоно.

ӨНДӨР НАСТНЫ ТОО, ӨСӨЛТ,  
НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

## 2.1. ӨНДӨР НАСТНЫ ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Монгол Улсын хөгжлийн түүхэн хандлагатай уялдаатайгаар хүн амын өсөлт, өндөр настны тоо, насны бүтэц өөрчлөгдсөөр ирэв. Өндөр настны тоо, бүтцийн өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодруулахын тулд 1956 оны тооллогоос эхлэн хүн амын төрөлт, өсөлтөд нөлөөлсөн зарим онцлог хүчин зүйлстэй холбон үзэх шаардлага гарч байна.

### ХҮСНЭГТ 2. 1. ӨНДӨР НАСТНЫ ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, 1956-2020 ОН

Он	Хүн ам-Бүгд	Үүнээс: Өндөр настны тоо			Өндөр настны эзлэх хувь	Жилийн дундаж өсөлт, хувиар	
		60-64	65+	Бүгд		Өндөр настан	Бүх хүн ам
1956	845 481	32 419	52 743	85 162	10.1		
1963	1 017 158	35 810	63 988	99 798	9.8	2.3	2.6
1969	1 197 595	37 310	71 942	109 252	9.1	1.5	2.8
1979	1 595 006	36 659	79 082	115 741	7.3	0.6	2.9
1989	2 043 954	36 235	82 628	118 863	5.8	0.3	2.5
2000	2 373 493	42 292	82 003	124 295	5.2	0.4	1.4
2010	2 754 685	49 453	101 706	151 159	5.5	2.0	1.5
2020	3 296 866	96 433	135 596	232 029	7.0	5.9	2.2

Хүн амын тооны өөрчлөлт нь төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөр тодорхойлогддог. Тооллого хоорондын хүн амын өсөлт нь тухайн үеийн улс төр, нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн хөгжлөөс ихээхэн хамааралтай. Монгол Улсын хүн ам 2010-2020 оны хооронд 19.7 хувиар өсөж, жилийн дундаж өсөлт 2.2 хувь болсон бол өндөр настны жилийн дундаж өсөлт 5.9 хувьтай байна. Өндөр настай хүн амын өсөлт нь хүн амын төрөлт огцом өссөн 1950-иад оны дунд үед шинээр мэндэлсэн иргэд ахмад үеийнхний эгнээд орж байгаатай холбоотой.

Хүн амын тоо 1950-иад оны дунд үеэс хурдтай нэмэгдэж, 1989 он хүртэл жилд дунджаар 2.5-аас илүү хувиар өсч байв. Энэ нь ард түмний аж байдал, хүн амын эрүүл мэндийн түвшин дээшилж, төрөлт нэмэгдэхийн зэрэгцээ нас баралт буурч, гадаад шилжих хөдөлгөөн бараг байхгүй байсантай ч холбоотой байна.

1989-2010 оны хооронд гурван 10 жил дараалан нийт хүн амын 5 орчим хувийг өндөр настан эзэлж байсан бол 2020 онд 7.0 хувь болж өсжээ. Нийт хүн амд өндөр настны эзлэх хувь 1956-2000 онд буурч байсан нь төр засгаас хүн амаа өсгөх талаар хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд хүүхэд, залуучуудын тоо эрс нэмэгдэж байсантай холбоотой юм. Өндөр настан хүн амын 2010-2020 оны жилийн дундаж өсөлт өмнөх тооллогуудын жилийн дундаж өсөлтөөс хамгийн өндөр нь байна.


ХҮСНЭГТ 2. 2. ӨНДӨР НАСТНЫ ТОО, ӨСӨЛТ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 1989, 2000, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Өндөр настны тоо				Хүн амын тооны өсөлт		
	1989	2000	2010	2020	2000/1989	2010/2000	2020/2010
<b>ДҮН</b>	<b>118 863</b>	<b>124 295</b>	<b>151 159</b>	<b>232 029</b>	<b>104.6</b>	<b>121.6</b>	<b>153.5</b>
60-64	36 233	42 292	49 453	96 433	116.7	116.9	195.0
65-69	31 488	35 415	38 232	55 279	112.5	108.0	144.6
70-74	22 476	20 239	29 332	32 748	90.0	144.9	111.6
75-79	16 166	14 843	18 617	25 113	91.8	125.4	134.9
80+	12 498	11 506	15 525	22 456	92.1	134.9	144.6

Сүүлийн 4 удаагийн тооллогын дүнгээс харахад өндөр настан хүн амын тоо тасралтгүй өссөн байна. Харин 1989-2000 онд 70, түүнээс дээш насны хүн амын тоо 4.6 мянган хүнээр буурч байжээ. Өмнөх хоёр 10 жилд өндөр настан хүн амын 3/5 орчмыг 60-69 насныхан эзэлж байсан бол 2010-2020 онд өндөр настан хүн амын тоо 80.9 мянган хүнээр нэмэгдсэн ба 65.4 хувийг 60-69 насныхан эзэлж байна.

Хүн амын насны бүтэц нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Хүн амын төрөлт, нас баралтын түвшнээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын нас, хүйсийн бүтцийг тодорхой харуулах дүрслэл бол нас, хүйсийн суварга юм.

ЗУРАГ 2. 1. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2000, 2010, 2020 ОН



Хүн ам, орон сууцны сүүлийн гурван удаагийн тооллогын дүнгээр 60, түүнээс дээш насны хүн амын нас, хүйсийн суваргыг зэрэгцүүлбэл нэлээд ялгаатай болж ирсэн нь тодорхой ажиглагдаж байна. Тухайлбал, 2000 оны байдлаар 60, түүнээс дээш настай хүн амын тоо 2010 оныхоос бага байгаа нь 50-60-аад жилийн өмнөх хүн амын төрөлт бага, нас баралт, үүний дотор нялхсын эндэгдэл өндөр байсантай холбоотойг илтгэнэ. Харин 2020 оны тооллогын дүнгээр хүн амын нас, хүйсийн суваргын хүрээ өмнөх 2 тооллогын дүнгээс нэлээд өргөссөн байгаа нь 1955 оноос төрөөс хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн бодлогын дүнд хүн амын төрөлт нэмэгдсэнийг харуулж байна. Нийт хүн амын дунд өндөр настны

эзлэх хувийн жин өмнөх тооллогын дүнгээс нэмэгдсэнээс гадна хүйсийн харьцаанд өөрчлөлт орсоноос суваргын хүрээ ийнхүү өндөр настны насны бүлэг бүрд, ялангуяа эмэгтэйчүүдийнх илүү өргөн болж байгаагаас тодорхой харагдана.

## ХҮСНЭГТ 2. 3. ӨНДӨР НАСТНЫ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2000			2010			2020		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>БҮГД</b>									
60-64	20 778	21 514	42 292	22 106	27 347	49 453	41 536	54 897	96 433
65-69	15 982	19 433	35 415	17 262	20 970	38 232	22 645	32 634	55 279
70-74	8 766	11 473	20 239	13 081	16 251	29 332	12 787	19 961	32 748
75-79	5 832	9 011	14 843	7 252	11 365	18 617	9 955	15 158	25 113
80+	3 634	7 872	11 506	5 112	10 413	15 525	7 597	14 859	22 456
ДҮН	54 992	69 303	124 295	64 813	86 346	151 159	94 520	137 509	232 029
<b>ХОТ</b>									
60-64	10 658	11 231	21 889	15 234	19 490	34 724	27 742	38 418	66 160
65-69	8 145	10 335	18 480	11 578	14 426	26 004	15 279	22 874	38 153
70-74	4 579	6 367	10 946	8 594	10 962	19 556	8 938	14 200	23 138
75-79	3 197	4 766	7 963	4 742	7 642	12 384	6 720	10 342	17 062
80+	1 952	4 131	6 083	3 500	6 946	10 446	5 074	9 800	14 874
ДҮН	28 531	36 830	65 361	43 648	59 466	103 114	63 753	95 634	159 387
<b>ХӨДӨӨ</b>									
60-64	10 120	10 283	20 403	6 872	7 857	14 729	13 794	16 479	30 273
65-69	7 837	9 098	16 935	5 684	6 544	12 228	7 366	9 760	17 126
70-74	4 187	5 106	9 293	4 487	5 289	9 776	3 849	5 761	9 610
75-79	2 635	4 245	6 880	2 510	3 723	6 233	3 235	4 816	8 051
80+	1 682	3 741	5 423	1 612	3 467	5 079	2 523	5 059	7 582
ДҮН	26 461	32 473	58 934	21 165	25 880	48 045	30 767	41 875	72 642

Өндөр настны тоо 2000-2010 оны хооронд 26.9 мянган хүнээр буюу жилд дунджаар 2.0 хувиар, 2010-2020 оны хооронд 80.9 мянган хүнээр буюу жилд дунджаар 5.9 хувиар тус тус өсжээ. Хүн амын төрөлт 1950-иад оны сүүлээс 1970-аад оны дунд үе хүртэл эрчимтэй өсөж, 1980-1990 онд аажим, харин 1990-1995 онд нэлээд буурч байснаа, 2003 оноос эхлэн төрөлт нэмэгдсэнээр хүн амын өсөлтөд эергээр нөлөөлж, нийт хүн амын өсөлтийн хурд тогтворжих, улмаар өндөр настны тоо нэмэгдэх хандлага бий болжээ.

Мөн нийт өндөр настнуудын дийлэнх буюу 2000 оны тооллогын дүнгээр 52.6 хувь, 2010 онд 68.2 хувь, 2020 онд 68.7 хувь нь төв, суурин газар амьдарч байна.



ХҮСНЭГТ 2. 4. ӨНДӨР НАСТНЫ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2000			2010			2020		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>БҮГД</b>									
60-64	1.8	1.8	1.8	1.7	2.1	1.9	2.6	3.3	2.9
65-69	1.4	1.6	1.5	1.3	1.6	1.4	1.4	1.9	1.7
70-74	0.7	1.0	0.9	1.0	1.2	1.1	0.8	1.2	1.0
75-79	0.5	0.8	0.6	0.6	0.9	0.7	0.6	0.9	0.8
80+	0.3	0.7	0.5	0.4	0.8	0.6	0.5	0.9	0.7
ДҮН	4.7	5.8	5.2	4.9	6.5	5.7	5.8	8.2	7.0
<b>ХОТ</b>									
60-64	1.6	1.6	1.6	1.7	2.1	1.9	2.5	3.3	2.9
65-69	1.2	1.5	1.4	1.3	1.6	1.4	1.4	2.0	1.7
70-74	0.7	0.9	0.8	1.0	1.2	1.1	0.8	1.2	1.0
75-79	0.5	0.7	0.6	0.5	0.8	0.7	0.6	0.9	0.8
80+	0.3	0.6	0.5	0.4	0.8	0.6	0.5	0.8	0.7
ДҮН	4.3	5.4	4.9	5.0	6.5	5.8	5.8	8.2	7.1
<b>ХӨДӨӨ</b>									
60-64	1.9	2.0	2.0	1.6	1.9	1.7	2.6	3.2	2.9
65-69	1.5	1.8	1.6	1.3	1.6	1.4	1.4	1.9	1.7
70-74	0.8	1.0	0.9	1.0	1.3	1.2	0.7	1.1	0.9
75-79	0.5	0.8	0.7	0.6	0.9	0.7	0.6	0.9	0.8
80+	0.3	0.7	0.5	0.4	0.8	0.6	0.5	1.0	0.7
ДҮН	5.1	6.4	5.7	4.8	6.5	5.7	5.8	8.2	7.0

Монгол Улсын нийт хүн амд өндөр настны эзлэх хувь 2000 онд хамгийн бага байсан бөгөөд сүүлийн 2 тооллогын хувьд өсжээ. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр нийт хүн амын 5.7 хувь, 2020 оны тооллогын дүнгээр 7.0 хувийг өндөр настнууд эзэлж байна. Энэ нь 1950-иад оны үеэс тус улсын эдийн засаг, нийгмийн хөгжил хурдасч, эрүүл мэндийн боловсрол, үйлчилгээ сайжирч байсантай холбоотойгоор хүн амын төрөлт нэмэгдэж эхэлсэн юм. Түүнчлэн 1950-иад оны сүүлээр хүн амыг эрүүлжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ үүний дотор арьс өнгө, сүрьеэ өвчтэй хүмүүсийг, үнэ төлбөргүй эмчлэн эдгэрүүлэх арга хэмжээ авсан билээ. Манай орны эрүүлийг хамгаалах систем тууштай хөгжихийн хэрээр хүн амын нас баралт, ялангуяа хүүхдийн болон нялхсын эндэгдэл нэлээд буурсан нь төрөлт нэмэгдэж, хүн амын өсөлтийн хурд өндөр байсан үед төрсөн иргэд өндөр насанд шилжиж эхэлсэн тул өндөр настны тоо өмнөх үеийнхээсээ өсөх төлөв ажиглагдаж байна.

ХҮСНЭГТ 2. 5. ӨНДӨР НАСТНЫ ХҮН АМ ЗҮЙН ҮНДСЭН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 1989, 2000, 2010, 2020 ОН


Үзүүлэлт	1989	2000	2010	2020
Хүйсийн харьцаа	77.8	79.4	75.1	68.7
Нийт хүн амд эзлэх хувийн жин	5.8	5.2	5.7	7.0
Голч нас	63.7	62.8	62.3	66.5
Насжилтын индекс	13.9	14.6	12.2	22.4
Жилийн дундаж өсөлт	0.3	0.4	2.0	5.9

Өндөр настны хүйсийн харьцааг (100 эмэгтэйд ногдох эрэгтэй) авч үзвэл 1989 онд 100 эмэгтэйд 78.0 ногдож байсан бол 2020 оны тооллогын дүнгээр 69.0 болжээ. Манай улсын өндөр настны хувьд хүйсийн харьцаа олон улсын дунджаас нэлээд доогуур байдаг нь эмэгтэйчүүдийн дундаж нас эрэгтэйчүүдийнхээс өндөр байдагтай холбоотой. Нас ахих тутам хүйсийн харьцаа буурч байгаа нь эрэгтэйчүүдийн нас баралтын түвшинтэй холбоотой.

Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа зааг насыг “Голч нас” гэдэг. Өөрөөр хэлбэл, 2020 онд өндөр настнуудын голч нас 66.5 болсон нь нийт өндөр настай хүн амын 50 хувь нь 66.5-аас доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна гэсэн үг юм. Сүүлийн 30 жилийн хугацаанд өндөр настны голч нас бараг 3 насаар хойшилсон нь хүн амын дундаж наслалт нэмэгдэж байгаатай холбоотой юм.

2020 оны тооллогоор 15 хүртэлх настай 100 хүүхдэд 60, түүнээс дээш насны өндөр настан 22.4 ногдож байна.

ЗУРАГ 2. 2. ӨНДӨР НАСТНЫ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, 2000, 2010, 2020 ОН




Манай улсын нийт хүн амын хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэй) 2000 оны тооллогоос хойш бага зэрэг буурч байгаа нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байдагтай холбоотой.

Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам мэдэгдэхүйцээр буурч байгаа нь зүй ёсны хандлага гэж үзэж болох талтай юм. Дэлхийн хүн ам зүйн олон жилийн судалгаанаас үзэхэд төрөх үеийн хүйсийн харьцаа дунджаар 104-106 хооронд байдаг бол Монгол Улсад төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа сүүлийн 10 жилд 105 буюу дэлхийн дундаж түвшинд байна.

Өндөр настны хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам буурч байгаа нь эмэгтэйчүүд харьцангуй урт насалж байгаатай холбоотой болохыг дээр дурдсан. Тухайлбал, 60-64 насны бүлэгт хүйсийн харьцаа 75.7, 65-69 насны бүлэгт 69.4 байсан бол ахимаг настны бүлэг 70, түүнээс дээших насанд хүйсийн харьцаа 65.7-51:1 болж огцом буурч байгаагаас харж болно.

ЗУРАГ 2. 3. ӨНДӨР НАСТНЫ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН



Өндөр настны хүйсийн харьцаа хотод 66.7, хөдөөд 73.5 байгаа нь амьдралын хэв маяг, хөдөлмөр эрхлэлттэй ч холбоотой байж болох юм. Өндөр настны хүйсийн харьцааг насны бүлгээр авч үзэхэд 80, түүнээс дээш насны бүлгээс бусад насны бүлгүүдэд хөдөөд өндөр настны хүйсийн харьцаа өндөр байна.

Олон улсын нийтлэг жишгийг харгалзан өндөр настныг 60-64, 65-74, 75+, түүнээс дээш настай гэж ангилж, насных нь бүтцийг тодорхойлов. Нийт өндөр настны дунд 60-64 насныхан тэтгэвэр тогтоолгон авах эрх нь үүсээд удаагүй, “Төрийн албаны тухай” Монгол Улсын хуулийн дагуу төрийн албан хаагч нь 65 нас хүртэл ажиллах боломжтой зэргийг үндэслэж өндөр настан дундаа харьцангуй “залуу” гэж үзэж болно. Харин 65-74 насны өндөр настан өөрийн боловсрол, мэргэжлийн чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг үндэслэн ажиллах, ялангуяа боловсрол, шинжлэх ухаан, удирдлагын салбар болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд оролцох боломжтой “дунд” насныхан болно. Харин 75-аас дээш насныхныг манай орны нөхцөлд ажиллах чадвар нь буурсан, асаргаа сувилгаа, нийгмийн халамжийн үйлчилгээг насны өмнөх 2 бүлгийнхнээс илүү шаарддаг зэргийг үндэслэн “ахимаг настан” гэж ангилж, судалгаанд тусгав.


ХҮСНЭГТ 2. 6. ӨНДӨР НАСТНЫ ТОО, ХОТ, ХӨДӨӨ, НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН

Байршил	2000				2010				2020			
	Бүгд	60-64	65-74	75+	Бүгд	60-64	65-74	75+	Бүгд	60-64	65-74	75+
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>34.0</b>	<b>44.8</b>	<b>21.2</b>	<b>100.0</b>	<b>32.7</b>	<b>44.7</b>	<b>22.6</b>	<b>100.0</b>	<b>41.6</b>	<b>37.9</b>	<b>20.5</b>
Хот	100.0	33.5	45.0	21.5	100.0	33.7	44.2	22.1	100.0	41.5	38.5	20.0
Хөдөө	100.0	34.6	44.5	20.9	100.0	30.7	45.8	23.5	100.0	41.7	36.8	21.5

Монгол Улсын өндөр настан хүн амыг 3 насны бүлэгт хуваан 3 тооллогын дүнгээр харьцуулбал дараах дүр зураг харагдаж байна. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр нийт 60, түүнээс дээш насны нийт хүн амын 41.6 орчим хувийг 60-64 насныхан эзэлж байгаа ба өмнөх 2 тооллогын дүнгээс 7.6-8.9 пунктээр нэмэгджээ. Энэ нь 1950-аад оны сүүлээс эхлэн төрөөс авч хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд төрөлт нэмэгдэн тухайн үед төрсөн хүн ам одоо өндөр настанд шилжиж байгааг харуулж байна.

Харин 65-74 насны хүн ам 37.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх 2 тооллогоос 6.8-6.9 пунктээр буурчээ. Энэ нь 60-аад жилийн өмнөх хүн амын төрөлт бага, нас баралт өндөр байсантай холбоотой юм. Хот, хөдөөгийн хувьд насны бүтцэд эрс ялгаа ажиглагдахгүй байна.

ЗУРАГ 2. 4. НИЙТ ХҮН АМД 0-14, 60, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



Манай улсын хүн амын насны бүтцэд 2000 оноос нэлээд өөрчлөлт гарчээ. Хүн амын насны бүтэц идэршиж, хөдөлмөрийн насны хүн амын тоо хамгийн их байх үе буюу “хүн ам зүйн цонх”-ны үе эхлээд байна. Хүн ам зүйн энэхүү онцлог үе цаашид удаан үргэлжлэхгүй байж ч болох юм. Ийнхүү хүн амын насны бүтэц аажмаар өөрчлөгдөж, өндөр настны нийт хүн амд эзлэх хувь нэмэгдсээр байх нь тодорхой байна. Хүн амын төрөлт, өсөлтийн үе үеийн онцлогоос хамаарч хүн амын насны бүтцэд нэлээд өөрчлөлт гарч байсныг дээрх зургаас харж болно.

ХҮСНЭГТ 2. 7. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, 2000, 2010, 2020 ОН

Хүн ам зүйн ачаалал	2000	2010	2020
<b>БҮГД</b>	<b>69.5</b>	<b>48.8</b>	<b>62.7</b>
0-14 насаар	60.6	40.6	51.2
60+ насаар	8.9	8.2	11.4

Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илэрхийлэх гол үзүүлэлтийн нэг нь хүн ам зүйн ачаалал билээ. Хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоогоор тодорхойлдог. Хөдөлмөрийн насны (15-59 насны) буюу тэжээгч, тэжээлгэгчийн (0-14 настай хүүхэд, 60, түүнээс дээш насныхан) тооны харьцаагаар тодорхойлогддоогоороо энэ үзүүлэлт нь эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйлийн нөлөөг илэрхийлдэг ач холбогдолтой. Хүн ам зүйн ачаалал 2020 онд 62.7 болж 2000 оноос 6.8 пунктээр буурч, 2010 оноос 13.9 пунктээр өсжээ. Сүүлийн жилүүдэд өндөр настан хүн амын тоо өссөнөөс шалтгаалан хүн ам зүйн ачаалалд үзүүлэх нөлөөлөл нэмэгдсээр байна.

ХҮСНЭГТ 2. 8. ӨНДӨР НАСТНЫ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДАЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН

	2000			2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд оролцоогүй									
Шилжиж ирсэн	43.7	65.9	19.0	64.8	78.3	35.8	47.1	59.4	16.5
Үүнээс:									
1 жил хүртэл	2.1	3.3	0.8	2.3	2.9	1.1	0.3	0.4	0.1
1-4 жил	3.5	5.1	1.7	4.1	5.0	2.2	1.1	1.2	0.5
5-9 жил	2.9	4.1	1.5	6.1	8.2	1.7	2.6	3.4	0.7
10+ жил	35.2	53.5	15.0	52.2	62.2	30.8	43.1	54.4	15.2

Хүн амын тоо, бүтэц, байршилд нөлөөлдөг үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь шилжих хөдөлгөөн юм. Төв, суурин газарт байнга оршин суудаг өндөр настны дийлэнх нь шилжин ирсэн байхад хөдөөгийн өндөр настны 83.5 хувь нь уугуул нутагтаа амьдарч байна. Энэ нь шилжих хөдөлгөөний хувьд хөдөөнөөс хотруу шилжин суурьшигчдын дийлэнх нь залуу, идэр насныхан байж, хөдөөд гол төлөв ахмадууд төрсөн нутагтаа үлдэж байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 2. 9. ШИЛЖИН ИРСЭН ӨНДӨР НАСТАН, НАСНЫ БҮЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2000			2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
60-64	35.3	34.1	39.9	34.2	33.5	37.6	37.0	36.4	42.7
65-69	28.3	28.4	27.9	25.8	25.6	27.3	24.3	24.1	26.0
70-74	16.4	16.8	14.9	19.0	19.1	18.4	16.3	16.6	13.4
75-79	11.6	11.8	10.9	11.4	11.8	9.3	12.3	12.5	10.9
80+	8.4	8.9	6.4	9.6	10.0	7.4	10.1	10.4	6.9

Сүүлийн жилүүдэд өндөр настны шилжих хөдөлгөөн нэмэгдэж байгаагийн дотор шилжин ирэгчдийн 61.3 хувь нь 60-69 насныхан эзэлж байна.

3

БҮЛЭГ

# ӨНДӨР НАСТНЫ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, СУУЦНЫ НӨХЦӨЛ

### 3.1. ӨНДӨР НАСТНЫ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Өндөр настны гэр бүлийн байдал нь нийт хүн амын болон залуучуудын гэр бүлийн байдлаас нэлээд ялгаатай. Огт гэр бүл болоогүй хүний эзлэх хувь бага, бэлэвсэн хүний эзлэх хувь нэлээд өндөр байдаг онцлогтой. Өндөр настан хүн амын насны бүлэг ахих тутам бэлэвсэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс олон байна. Энэ нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдээс өндөр байдагтай холбоотой. Үүнтэй уялдан өндөр настны дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү, хүйсийн харьцаа бага байдгийг өмнө дурьдсан билээ.

ХҮСНЭГТ 3. 1. НИЙТ ХҮН АМЫН БОЛОН ӨНДӨР НАСТНЫ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН

Гэр бүлийн байдал	Нийт хүн ам		Өндөр настан	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
2000				
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл болоогүй	36.6	29.8	2.8	3.1
Гэр бүлтэй*	58.5	57.1	70.8	33.8
Цуцалсан**	2.1	3.3	2.0	1.0
Бэлэвсэн	2.8	9.8	24.4	62.1
2010				
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл болоогүй	34.4	28.2	2.4	2.9
Гэр бүлтэй*	60.7	59.6	76.4	43.9
Цуцалсан**	2.7	3.5	2.0	1.6
Бэлэвсэн	2.2	8.7	19.2	51.6
2020				
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл болоогүй	35.2	28.1	2.6	3.0
Гэр бүлтэй*	61.0	60.2	81.6	49.5
Цуцалсан**	2.0	2.8	2.6	2.6
Бэлэвсэн	1.8	8.9	13.2	44.9


\* батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

\*\*гэрлэлтээ цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Сүүлийн 3 тооллогын дүнгээр өндөр настнуудын гэр бүлийн байдлыг авч үзэхэд гэр бүлтэй өндөр настнуудын хувь нэмэгдэж, бэлэвсэн өндөр настнуудын хувийн жин буурчээ. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны эрэгтэй хүн амын 35.2 хувь нь огт гэр бүл болоогүй байгаа бол 60, түүнээс дээш насны эрэгтэй хүн амын 2.6 хувь нь огт гэрлээгүй байна. Мөн өндөр настан эрэгтэй хүн амын 13.2 хувь нь бэлэвсэн байгаа бол өндөр настан эмэгтэйчүүдийн 44.9 хувь нь бэлэвсэн байна. Мөн нас ахих тусам бэлэвсэн өндөр настнуудын эзлэх хувь нэмэгдэж байгаа бөгөөд ялангуяа 70, түүнээс дээш настай эмэгтэйчүүдийн дийлэнх нь бэлэвсэн байгаа нь эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү өндөр байдагтай холбоотой юм.



ЗУРАГ 3. 1. НИЙТ ӨНДӨР НАСТАНД БЭЛЭВСЭН ӨНДӨР НАСТНЫ ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН



Өндөр настны гэр бүлийн байдлыг насны бүлэг, хүйсээр ангилан үзвэл зарим үзүүлэлт ялгаатай байна (Хүснэгт 3.2).

ХҮСНЭГТ 3. 2. ӨНДӨР НАСТНЫ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Гэр бүлийн байдал	Насны бүлэг, хүйс								
	60-64			65-69			70-74		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>БҮГД</b>									
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл болоогүй	3.2	3.6	3.4	2.5	3.1	2.9	1.8	2.4	2.2
Батлуулсан гэр бүл	81.3	59.3	68.8	80.6	50.4	62.8	78.1	41.5	55.8
Батлуулаагүй гэр бүл	4.9	3.4	4.0	3.8	2.3	2.9	3.0	1.3	2.0
Тусгаарласан	1.7	1.8	1.8	1.3	1.1	1.2	0.8	0.7	0.7
Цуцалсан	1.8	2.3	2.0	1.2	1.4	1.3	0.9	0.6	0.7
Бэлэвсэн	7.2	29.5	19.9	10.6	41.7	29.0	15.4	53.5	38.6
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>41 171</b>	<b>54 182</b>	<b>95 353</b>	<b>22 496</b>	<b>32 387</b>	<b>54 883</b>	<b>12 732</b>	<b>19 835</b>	<b>32 567</b>
<b>ХОТ</b>									
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл болоогүй	2.9	2.9	2.9	2.4	2.1	2.3	1.6	1.4	1.4
Батлуулсан гэр бүл	80.7	59.0	68.1	80.0	51.4	62.8	78.0	43.1	56.6
Батлуулаагүй гэр бүл	5.6	4.0	4.7	4.3	2.6	3.3	3.5	1.4	2.2
Тусгаарласан	1.9	2.2	2.1	1.4	1.2	1.3	0.8	0.8	0.8
Цуцалсан	1.9	2.7	2.3	1.4	1.6	1.5	0.8	0.7	0.7
Бэлэвсэн	7.0	29.3	19.9	10.5	41.0	28.8	15.2	52.6	38.2
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>27 420</b>	<b>37 763</b>	<b>65 183</b>	<b>15 156</b>	<b>22 654</b>	<b>37 810</b>	<b>8 892</b>	<b>14 094</b>	<b>22 986</b>
<b>ХӨДӨӨ</b>									
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл болоогүй	3.8	5.3	4.6	2.8	5.2	4.2	2.3	5.1	4.0
Батлуулсан гэр бүл	82.3	60.1	70.2	81.7	48.3	62.7	78.3	37.8	54.0
Батлуулаагүй гэр бүл	3.3	2.0	2.6	2.6	1.6	2.0	1.8	0.9	1.3
Тусгаарласан	1.4	1.0	1.2	1.2	0.8	1.0	0.8	0.3	0.5
Цуцалсан	1.5	1.3	1.4	0.8	0.9	0.8	0.9	0.4	0.6
Бэлэвсэн	7.6	30.1	19.9	10.8	43.3	29.3	15.9	55.5	39.6
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>13 751</b>	<b>16 419</b>	<b>30 170</b>	<b>7 340</b>	<b>9 733</b>	<b>17 073</b>	<b>3 840</b>	<b>5 741</b>	<b>9 581</b>

Гэр бүлийн байдал	Насны бүлэг, хүйс								
	75-79			80+			Бүгд		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<b>БҮГД</b>									
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл болоогүй	1.7	2.2	2.0	1.7	2.5	2.2	2.6	3.0	2.9
Батлуулсан гэр бүл	71.2	31.9	47.5	58.8	18.7	32.3	77.8	47.2	59.7
Батлуулаагүй гэр бүл	2.3	1.1	1.6	2.0	0.8	1.2	3.8	2.3	2.9
Тусгаарласан	0.8	0.4	0.5	0.6	0.4	0.5	1.3	1.2	1.2
Цуцалсан	0.7	0.5	0.6	0.5	0.5	0.5	1.3	1.4	1.4
Бэлэвсэн	23.3	63.8	47.8	36.4	77.2	63.4	13.2	44.9	32.0
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>9 922</b>	<b>15 094</b>	<b>25 016</b>	<b>7 578</b>	<b>14 807</b>	<b>22 385</b>	<b>93 899</b>	<b>136 305</b>	<b>230 204</b>
<b>ХОТ</b>									
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл болоогүй	1.4	1.1	1.2	1.2	1.4	1.3	2.3	2.1	2.2
Батлуулсан гэр бүл	71.4	33.8	48.6	60.2	20.6	34.1	77.5	48.1	59.9
Батлуулаагүй гэр бүл	2.6	1.3	1.8	2.2	0.8	1.3	4.4	2.6	3.4
Тусгаарласан	0.7	0.5	0.6	0.6	0.4	0.5	1.4	1.4	1.4
Цуцалсан	0.8	0.6	0.6	0.5	0.5	0.5	1.4	1.7	1.6
Бэлэвсэн	23.2	62.8	47.2	35.3	76.3	62.3	13.0	44.1	31.6
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>6 697</b>	<b>10 287</b>	<b>16 984</b>	<b>5 059</b>	<b>9 764</b>	<b>14 823</b>	<b>63 224</b>	<b>94 562</b>	<b>157 786</b>
<b>ХӨДӨӨ</b>									
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Огт гэр бүл болоогүй	2.5	4.6	3.7	2.6	4.7	4.0	3.1	5.1	4.3
Батлуулсан гэр бүл	71.0	27.9	45.2	55.9	14.9	28.6	78.3	45.1	59.2
Батлуулаагүй гэр бүл	1.5	0.7	1.0	1.6	0.8	1.0	2.6	1.5	2.0
Тусгаарласан	0.9	0.2	0.5	0.6	0.3	0.4	1.2	0.7	0.9
Цуцалсан	0.5	0.5	0.5	0.6	0.3	0.4	1.1	0.9	1.0
Бэлэвсэн	23.5	66.2	49.0	38.7	79.0	65.6	13.7	46.7	32.7
<b>ХҮНИЙ ТОО</b>	<b>3 225</b>	<b>4 807</b>	<b>8 032</b>	<b>2 519</b>	<b>5 043</b>	<b>7 562</b>	<b>30 675</b>	<b>41 743</b>	<b>72 418</b>


Өндөр настны дунд гэр бүлтэй эрэгтэйчүүдийн эзлэх хувь бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийнхээс их байхад бэлэвсэн эмэгтэйчүүдийн хувь бүх насны бүлэгт эрэгтэйчүүдийнхээс их байна. Гэхдээ 2010 онтой харьцуулахад бэлэвсэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тухайн насны бүлэгт эзлэх хувь аль ч насны бүлэгт буурсан байна. Энэ нь эрт бэлэвсэрдэг тохиолдол буурч байгааг харуулж байна. Харин эрэгтэйчүүдтэй харьцуулахад бэлэвсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа нь эмэгтэйчүүд дахин гэрлэх магадлал эрэгтэйчүүдээс бага байж, өрх толгойлох болсонтой гэж дүгнэж болох юм. Бэлэвсэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2010 онд 24 мянгаар илүү байсан бол энэ тоо 2020 онд бараг 2 дахин нэмэгдсэн (48.8 мянга) бөгөөд бэлэвсэн өндөр настны 68.6 хувь нь хотод, 31.4 хувь нь хөдөөд байна. Өндөр настны гэр бүлийн ерөнхий төлөв байдал тэдний байнга оршин суудаг газар (хот, хөдөөгөөр)-аар онцын ялгаа байхгүй байна.

### 3.2. ӨНДӨР НАСТНЫ ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ, ӨНДӨР НАСТАН ӨРХ


Судалгааны энэ хэсэг нь өндөр настаны өрхийн тэргүүлэгчийн хамаарал, өндөр настан өрх гэсэн хэсгүүдээс бүрэлдэж байна. **Өрхийн тэргүүлэгчийн хамаарал.** Энэ бүлэгт өндөр настан өөрөө өрхийн тэргүүлэгч, эсвэл өрхийн тэргүүлэгч биш бол өндөр настаны эхнэр/ нөхөр, эсвэл өндөр настантай өрхийг харуулав. Энэ нь өндөр настаны хүн ам зүйн төдийгүй тэдний нийгэм, өрх, гэр бүлдээ гүйцэтгэх үүрэг, хариуцлага, амьдралын хэв маягийг илэрхийлнэ.

Нийт өндөр настаны 65.8 хувь буюу 151.4 мянга нь өрхийн тэргүүлэгч байгаагийн 55.9 хувийг эрэгтэйчүүд, 44.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь тухайн гэр бүлийн гишүүдийн нөхөр нь амьд сэрүүн байгаа тохиолдолд эрэгтэй нь өрхөө тэргүүлдэг монголын уламжлалт заншилтай холбоотой.

ЗУРАГ 3. 2. ӨНДӨР НАСТНЫ ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН



- Өрхийн тэргүүлэгч-90.1%
- Эхнэр, нөхөр-0.7%
- Хүү, охин-0.2%
- Хамааралгүй-9.0%



- Өрхийн тэргүүлэгч-49.0%
- Эхнэр, нөхөр-32.8%
- Хүү, охин-0.2%
- Хамааралгүй-18.0%

Нийт өндөр настан эрэгтэйчүүдийн 90.1 хувь өрхийн тэргүүн байгаа нь монголын уламжлалт заншил хэвээр хадгалагдаж байгааг харуулж байна. Харин өндөр настан эмэгтэйчүүдийн 49.0 хувь нь өрхийн тэргүүлэгч байна.

**Өндөр настан тэргүүлэгчтэй өрх.** Өрхийн тэргүүлэгч нь 60, түүнээс дээш настай өрхийг өндөр настан өрх гэж үзэв. Өрхийн талаарх ойлголт, тодорхойлолтыг судалгааны нэгдүгээр бүлгээс үзнэ үү.

ХҮСНЭГТ 3. 3. ӨНДӨР НАСТАН ӨРХ, ӨРХӨД ТООЛОГДСОН ХҮНИЙ ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН


Өрхөд тоологдсон хүний тоо	Өрхийн тэргүүлэгч нь 60, түүнээс дээш настай	Ганц бие өрх	Ам бүлээрээ байгаа өрх	Нийлмэл өрх	Холимог өрх
2010					
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>10.6</b>	<b>62.4</b>	<b>24.9</b>	<b>2.1</b>
1	100.0	100.0	-	-	-
2	100.0	-	80.2	18.1	1.6
3-4	100.0	-	77.3	20.9	1.8
5-6	100.0	-	53.3	43.3	3.5
7+	100.0	-	23.8	70.3	5.8
<b>ХОТ</b>	<b>100.0</b>	<b>9.9</b>	<b>57.5</b>	<b>30.3</b>	<b>2.4</b>
1	100.0	100.0	-	-	-
2	100.0	-	77.9	20.3	1.8
3-4	100.0	-	73.9	25.0	2.0
5-6	100.0	-	41.9	54.1	3.9
7+	100.0	-	13.2	80.2	6.5
<b>ХӨДӨӨ</b>	<b>100.0</b>	<b>12.2</b>	<b>72.3</b>	<b>13.9</b>	<b>1.5</b>
1	100.0	100.0	-	-	-
2	100.0	-	84.9	13.7	1.3
3-4	100.0	-	86.4	12.3	1.3
5-6	100.0	-	75.7	21.8	2.6
7+	100.0	-	56.3	40.0	3.7
2020					
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>25.4</b>	<b>40.6</b>	<b>32.0</b>	<b>2.0</b>
1	100.0	100.0	-	-	-
2	100.0	-	88.3	10.8	0.9
3-4	100.0	-	51.8	45.9	2.3
5-6	100.0	-	11.4	84.3	4.3
7+	100.0	-	1.3	90.1	8.5
<b>ХОТ</b>	<b>100.0</b>	<b>21.1</b>	<b>37.2</b>	<b>38.8</b>	<b>2.9</b>
1	100.0	100.0	-	-	-
2	100.0	-	86.5	12.2	1.3
3-4	100.0	-	46.5	50.4	3.1
5-6	100.0	-	8.7	86.2	5.1
7+	100.0	-	0.8	89.9	9.3
<b>ХӨДӨӨ</b>	<b>100.0</b>	<b>33.9</b>	<b>47.6</b>	<b>18.2</b>	<b>0.3</b>
1	100.0	100.0	-	-	-
2	100.0	-	91.1	8.6	0.3
3-4	100.0	-	64.2	35.3	0.5
5-6	100.0	-	23.3	76.1	0.6
7+	100.0	-	6.0	92.5	1.6

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийт өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн бүтцийн хувьд авч үзвэл 40.6 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 32.0 хувь нь

нийлмэл<sup>2</sup> ам бүлтэй өрх, 25.4 хувь нь ганц бие өрх, 2.0 хувь нь холимог<sup>3</sup> ам бүлтэй өрх байна. Өмнөх тооллогын дүнгээс ганц бие өрх 14.8 пунктээр, нийлмэл өрх 7.1 пунктээр тус тус өссөн бол ам бүлээрээ өрх 21.8 пунктээр, холимог өрх 0.1 пунктээр тус тус буурчээ. Манай улсад ам бүлээрээ эсвэл садан төрлөөрөө хамтран нэг өрх болон амьдардаг уламжлалт хэв шинж хэвээр хадгалагдаж байгааг улсын хэмжээний болон өндөр настан өрхүүдийг өрхийн хэлбэрээр ангилсан үзүүлэлтээс харж болно. Ганц бие өндөр настан өрхийн эзлэх хувь өмнөх тооллогын дүнгээс 14.8 пунктээр өссөн нь анхаарал татах асуудал болж байна. Энэ нь ахмадуудын оршин сууж байгаа орон нутгийн төр, захиргааны байгууллагаас тэдний нийгмийн асуудалд илүү анхаарах шаардлагатайг харуулж байна.

Хөдөөгийн өрхийн дунд ам бүлээрээ байгаа өрх хотынхоос 10.4 пунктээр илүү байгаа нь иргэд өөрсдөө монголын уламжлалт сууц болох гэр болон зарим нутагт байшин барьж амьдрах нөхцөл боломж илүү байдагтай холбоотой.

ЗУРАГ 3. 3. ӨНДӨР НАСТАН ӨРХ, ӨРХӨД ТООЛОГДСОН ХҮНИЙ ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН



Өндөр настан өрхийн 53.8 хувь нь 1-2 гишүүнтэй байгаа бол хөдөөгийн 67.3 хувь нь, хотын 47.0 хувь нь 1-2 гишүүнтэй байна. Харин 5, түүнээс дээш гишүүнтэй өндөр настан өрхийн 18.9 хувь байгаа бол хотод 24.1 хувь, хөдөөд 8.5 хувь тус тус байна. Хот, суурин газрын өндөр настан өрхийн ам бүлийн гишүүдийн тоо өндөр байгаа нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой байхын зэрэгцээ хот, суурин газрын өрхөд хөдөөнөөс ирсэн оюутан, сурагчид болон хамаатан садан нь түр амьдарч байж болох юм. Мөн сууцны хүрэлцээ, хангамжаас шалтгаалан садан төрлөөрөө, танилаараа хэд хэдэн гэр бүл нэг өрх болон хамт амьдрах тохиолдол хот, суурин газарт түгээмэл байдагтай ч бас холбоотой.


<sup>2</sup> Хоорондоо хамааралтай хэд хэдэн ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг нийлмэл өрх гэнэ.

<sup>3</sup> Ураг төрлийн хамааралтай болон хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг холимог өрх гэнэ.

### 3.3. ӨНДӨР НАСТНЫ СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ

Хүний амьдралын анхдагч хэрэгцээ, байгаль, цаг уурын аливаа үзэгдэл, гадны нөлөө, бусдаас тусгаарлан эрүүл, тав тухтай, аюулгүй амьдрах үндсэн орчин бол сууц юм. Сууцны нөхцөл, дэд бүтцийн хангамж нь хүн амын амьжиргааны түвшин, амьдралын чанарыг үнэлэх боломжтой. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор өрхийн амьдарч байгаа сууцыг өөрийн орны онцлогтой уялдуулан байшин, гэр гэж үндсэнд нь хоёр төрөл болгож, тооллогын хуудсанд тус тусад нь хариулт авахаар тусгасан. Энэ нь тэдгээр сууцны хийц, бүтэц, ахуй нөхцлийн үзүүлэлт ялгаатай байдагтай холбоотой юм.

ЗУРАГ 3. 4. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН



Өндөр настан нийт өрхийн 62.8 хувь нь байшинд, 37.2 хувь нь гэрт амьдарч байна. Хот, хөдөөд амьдарч байгаа өндөр настны өрхийн сууцны төрөл нилээд ялгаатай байна. Өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн 51.8 хувь нь хотод орон сууцны байшинд амьдарч байгаа бол хөдөөгийн өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн 91.5 хувь нь сууцны тусдаа байшинд амьдарч байна. Хот, хөдөөд байшинд амьдардаг өндөр настны тоо өсч байгаа нь иргэд өөрсдөө байшин барьж, амьдрах бололцоо нэмэгдсэн явдал юм.

Энэ удаагийн тооллогоор сууцны талаарх мэдээллийг байшингийн төрөл, сууцны өмч, эзэмшлийн хэлбэрээр нарийвчлан ангилж авсан нь хүн амын сууцны хангамж, амьжиргааг бодитой үнэлэх боломж олгож байна. Түүнчлэн өрхийн халаалт, ундны усны хангамж зэрэг дэд бүтцийг тодорхойлох үндсэн үзүүлэлтийг ч

нарийвчлан тодорхойлсон нь өмнөх тооллогын дүнтэй шууд харьцуулах боломжгүй ч тодорхой хүрээнд үнэлгээг хийж болох юм.

### ХҮСНЭГТ 3. 4. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАНТАЙ ӨРХИЙН ТОО, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ӨМЧ, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Сууцны төрөл, хэлбэр, зориулалт	Бүгд		Хот		Хөдөө		
	Өрхийн тоо	Хувь	Өрхийн тоо	Хувь	Өрхийн тоо	Хувь	
2010							
<b>БҮГД</b>	<b>72 604</b>	<b>100.0</b>	<b>61 250</b>	<b>100.0</b>	<b>11 354</b>	<b>100.0</b>	
Байшингийн төрөл	Орон сууцны байшин	31 104	42.8	30 690	50.1	414	3.6
	Бие даасан тохилог сууц	771	1.1	765	1.2	6	0.1
	Сууцны тусдаа байшин	39 384	54.2	28 700	46.9	10 684	94.1
	Оюутан сурагчдын нийтийн байр	80	0.1	71	0.1	9	0.1
	Ажилчдын нийтийн байр	906	1.2	725	1.2	181	1.6
	Нийтийн зориулалттай бусад	359	0.5	299	0.5	60	0.5
Сууцны өмчийн хэлбэр	Төрийн өмчийн	798	1.1	623	1.0	175	1.5
	Аж ахуй нэгж байгууллагын	948	1.3	788	1.3	160	1.4
	Иргэний	70 858	97.6	59 839	97.7	11 019	97.0
Сууцны эзэмшлийн хэлбэр	Өөрийн эзэмшлийн	66 192	91.2	55 826	91.1	10 366	91.3
	Бусдын сууцанд түрээстэй суудаг	2 811	3.9	2 613	4.3	198	1.7
	Бусдын сууцанд түрээсгүй суудаг	3 225	4.4	2 518	4.1	707	6.2
	Бусад	376	0.5	293	0.5	83	0.7
2020							
<b>БҮГД</b>	<b>118 568</b>	<b>100.0</b>	<b>97 597</b>	<b>100.0</b>	<b>20 971</b>	<b>100.0</b>	
Байшингийн төрөл	Орон сууцны байшин	54 437	45.9	52 785	54.1	1 652	7.9
	Бие даасан тохилог сууц	1 460	1.2	1 377	1.4	83	0.4
	Сууцны тусдаа байшин	61 276	51.7	42 265	43.3	19 011	90.7
	Нийтийн байр	1 313	1.1	1 101	1.1	212	1.0
	Нийтийн зориулалттай бусад байр	82	0.1	69	0.1	13	0.1
Сууцны өмчийн хэлбэр	Төрийн өмчийн	913	0.8	739	0.8	174	0.8
	Аж ахуй нэгж байгууллагын	669	0.6	412	0.4	257	1.2
	Иргэний	116 986	98.7	96 446	98.8	20 540	97.9
Сууцны эзэмшлийн хэлбэр	Өөрийн эзэмшлийн	110 227	93.0	90 385	92.6	19 842	94.6
	Бусдын сууцанд түрээстэй суудаг	3 693	3.1	3 380	3.5	313	1.5
	Бусдын сууцанд түрээсгүй суудаг	4 331	3.7	3 542	3.6	789	3.8
	Бусад	317	0.3	290	0.3	27	0.1

Өндөр настан амьдардаг өрхийн 98.7 хувь нь хувийн өмчийн сууцтай, үлдсэн хэсэг нь төрийн болон холимог өмчийн сууцад, 93.0 хувь нь өөрийн эзэмшлийн сууцад амьдарч байна. Өндөр настны амьдарч байгаа сууцыг байшингийн төрлөөр авч үзвэл өрхийн 51.7 хувь нь сууцны тусдаа байшинд, 45.9 хувь нь орон сууцны байшинд, 1.2 хувь нь бие даасан тохилог сууцанд, 1.1 хувь нь нийтийн байранд, 0.1 хувь нь зориулалтын бус сууцад амьдарч байна.

Харин өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн 98.7 хувь нь иргэний өмчийн сууцанд, 93.4 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд амьдарч байгаа нь бусад улс оронтой харьцуулахад нэлээд давуу талтай байна. Өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн 2.8 хувь нь бусдын сууцанд түрээс төлж амьдарч байна. Өрхийн сууцыг төрлөөр нь ангилж үзвэл байшинд амьдарч байгаа өрхийн 43.3 хувь орон сууцны байшинд, 54.3

хувь сууцны тусдаа байшинд, 1.3 хувь бие даасан тохилог сууцанд амьдарч, энэ өрхүүдийн 80.8 хувь хотод амьдарч байна.

**ХҮСНЭГТ 3. 5. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН ТОО, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ӨМЧ, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН**

Сууцны төрөл, хэлбэр, зориулалт		Бүгд		Хот		Хөдөө	
		Өрхийн тоо	Хувь	Өрхийн тоо	Хувь	Өрхийн тоо	Хувь
		2010					
<b>БҮГД</b>		<b>50 506</b>	<b>100.0</b>	<b>41 800</b>	<b>100.0</b>	<b>8 706</b>	<b>100.0</b>
Байшингийн төрөл	Орон сууцны байшин	20 724	41.0	20 431	48.9	293	3.4
	Бие даасан тохилог сууц	465	0.9	460	1.1	5	0.1
	Сууцны тусдаа байшин	28 383	56.2	20 161	48.2	8 222	94.4
	Оюутан, сурагчдын нийтийн байр	47	0.1	43	0.1	4	0.0
	Ажилчдын нийтийн байр	627	1.2	492	1.2	135	1.6
	Нийтийн зориулалттай бусад	260	0.5	213	0.5	47	0.5
Сууцны өмчийн хэлбэр	Төрийн өмчийн	518	1.0	399	1.0	119	1.4
	Аж ахуй нэгж байгууллагын	648	1.3	517	1.2	131	1.5
	Иргэний	49 340	97.7	40 884	97.8	8 456	97.1
Сууцны эзэмшлийн хэлбэр	Өөрийн эзэмшлийн	45 930	90.9	38 044	91.0	7 886	90.6
	Бусдын сууцанд түрээстэй суудаг	1 774	3.5	1 637	3.9	137	1.6
	Бусдын сууцанд түрээсгүй суудаг	2 532	5.0	1 918	4.6	614	7.1
	Бусад	270	0.5	201	0.5	69	0.8
		2020					
<b>БҮГД</b>		<b>95 760</b>	<b>100.0</b>	<b>77 350</b>	<b>100.0</b>	<b>18 410</b>	<b>100.0</b>
Байшингийн төрөл	Орон сууцны байшин	41 441	43.3	40 139	51.9	1 302	7.1
	Бие даасан тохилог сууц	1 198	1.3	1 126	1.5	72	0.4
	Сууцны тусдаа байшин	52 006	54.3	35 161	45.5	16 845	91.5
	Нийтийн байр	1 042	1.1	864	1.1	178	1.0
	Нийтийн зориулалттай бусад байр	73	0.1	60	0.1	13	0.1
Сууцны өмчийн хэлбэр	Төрийн өмчийн	736	0.8	588	0.8	148	0.8
	Аж ахуй нэгж байгууллагын	537	0.6	314	0.4	223	1.2
	Иргэний	94 487	98.7	76 448	98.8	18 039	98.0
Сууцны эзэмшлийн хэлбэр	Өөрийн эзэмшлийн	89 479	93.4	71 990	93.1	17 489	95.0
	Бусдын сууцанд түрээстэй суудаг	2 673	2.8	2 433	3.1	240	1.3
	Бусдын сууцанд түрээсгүй суудаг	3 381	3.5	2 723	3.5	658	3.6
	Бусад	227	0.2	204	0.3	23	0.1

Өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн сууцны нөхцлийг олон улсын нийтлэг жишиг байдлаар өмнөх тооллогоос арай дэлгэрүүлэн, өндөр настны амьдрах орчин, түүний ахуй нөхцлийг өөрийн орны онцлогийг харгалзан үзүүлэх зорилт тавьсан болно.



ХҮСНЭГТ 3. 6. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХ, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР, 2010, 2020 ОН

Байшингийн төрөл	Бүгд	Төвлөрсөн систем	Нам даралтын зуух	Цахилгаан халаагуур	Ердийн галлагаа
2010					
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>43.9</b>	<b>3.7</b>	<b>0.4</b>	<b>52.0</b>
Орон сууцны байшин	41.0	100.0	0.0	-	-
Бие даасан тохилог сууц	0.9	87.5	9.5	3.0	-
Сууцны тусдаа байшин	56.2	2.4	6.0	0.7	90.9
Оюутан сурагчдын нийтийн байр	0.1	57.4	19.1	4.3	19.1
Ажилчдын нийтийн байр	1.2	34.6	8.3	0.6	56.5
Нийтийн зориулалттай бусад байр	0.5	40.0	14.2	1.5	44.2
<b>ХОТ</b>	<b>100.0</b>	<b>52.1</b>	<b>4.0</b>	<b>0.4</b>	<b>43.5</b>
Орон сууцны байшин	48.9	100.0	0.0	-	-
Бие даасан тохилог сууц	1.1	87.6	9.3	3.0	-
Сууцны тусдаа байшин	48.2	3.0	7.7	0.8	88.5
Оюутан сурагчдын нийтийн байр	0.1	58.1	18.6	4.7	18.6
Ажилчдын нийтийн байр	1.2	40.4	8.9	0.8	49.8
Нийтийн зориулалттай бусад байр	0.5	46.0	15.5	1.4	37.1
<b>ХӨДӨӨ</b>	<b>100.0</b>	<b>4.5</b>	<b>1.8</b>	<b>5.0</b>	<b>93.2</b>
Орон сууцны байшин	3.4	100.0	-	-	-
Бие даасан тохилог сууц	0.1	80.0	20.0	-	-
Сууцны тусдаа байшин	94.4	0.8	1.8	0.5	96.9
Оюутан сурагчдын нийтийн байр	0.0	50.0	25.0	-	25.0
Ажилчдын нийтийн байр	1.6	13.3	5.9	-	80.7
Нийтийн зориулалттай бусад байр	0.5	12.8	8.5	2.1	76.6
2020					
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>44.6</b>	<b>6.9</b>	<b>1.9</b>	<b>46.6</b>
Орон сууцны байшин	43.3	96.3	3.5	0.1	0.0
Бие даасан тохилог сууц	1.3	81.1	10.7	7.8	0.3
Сууцны тусдаа байшин	54.3	2.4	9.5	3.2	84.9
Нийтийн байр	1.1	44.8	7.0	2.9	45.3
Нийтийн зориулалттай бусад байр	0.1	43.8	12.3	11.0	32.9
<b>ХОТ</b>	<b>100.0</b>	<b>53.2</b>	<b>7.4</b>	<b>2.3</b>	<b>37.2</b>
Орон сууцны байшин	51.9	96.6	3.3	0.1	0.0
Бие даасан тохилог сууц	1.5	83.1	8.5	8.1	0.3
Сууцны тусдаа байшин	45.5	2.8	12.0	4.5	80.7
Нийтийн байр	1.1	48.7	7.6	3.4	40.3
Нийтийн зориулалттай бусад байр	0.1	41.7	15.0	11.7	31.7
<b>ХӨДӨӨ</b>	<b>100.0</b>	<b>8.2</b>	<b>4.9</b>	<b>0.5</b>	<b>86.3</b>
Орон сууцны байшин	7.1	87.8	11.8	0.1	0.3
Бие даасан тохилог сууц	0.4	50.0	44.4	4.2	1.4
Сууцны тусдаа байшин	91.5	1.7	4.2	0.5	93.5
Нийтийн байр	1.0	25.8	3.9	0.6	69.7
Нийтийн зориулалттай бусад байр	0.1	53.8	0.0	7.7	38.5

Сүүлийн жилүүдэд халаалтын олон төрлийн хэрэгсэл манай улсад орж ирснээр өрхийн халаалтын эх үүсвэрийн төрөл нэмэгдсэн. 2010 онд байшинд амьдардаг өрхийн 43.9 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон, 52.0 хувь нь ердийн галлагаатай, 3.7 хувь нь нам даралтын зуух, 0.4 хувь нь цахилгаан халаагуур хэрэглэж байсан бол 2020 онд байшинд амьдардаг өрхийн 44.6 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон, 46.6 хувь нь ердийн галлагаатай, 6.9 хувь нь нам даралтын зуух, 1.9 хувь нь цахилгаан халаагуур хэрэглэж, цөөхөн тооны өрхүүд газрын гүнийн дулаан, мөн шатдаг хийгээр халаалтаа хангаж байна. Орон сууцны байшинд амьдардаг өрхийн 96.3 хувь нь халаалтын төвлөрсөн системд холбогдсон байхад бие даасан тохилог сууцад амьдардаг өрхийн 81.1 хувь, нийтийн байранд амьдардаг өрхийн 44.8 хувь нь төвлөрсөн халаалтад холбогдсон байна. Харин сууцны тусдаа байшинтай өрхийн 84.9 хувь нь ердийн галлагаатай байна. Өрхийн халаалтын төрөл хот, хөдөөд нэлээд ялгаатай байна. Хотын өрхийн 53.2 хувь төвлөрсөн халаалттай, 37.2 хувь ердийн галлагаатай байхад хөдөөний өрхийн дийлэнх /86.3 хувь/ ердийн галлагаатай, 4.9 хувь нь нам даралтын зуух хэрэглэж байна. Ердийн галлагаатай болон нам даралтын зуух хэрэглэж байгаа өрхөд хүйтний улиралд түлээ, нүүрс ихээхэн хэрэгцээтэй байдаг. Байшинд амьдардаг өндөр настан өрхийн халаалтыг аймаг, нийслэлээр хавсралт 3.4-д үзүүлэв.

ЗУРАГ 3. 5. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАНТАЙ ӨРХИЙН ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, 2020 ОН



Хүн амын амьжиргааны түвшинг илэрхийлэх үзүүлэлтийн нэг бол цахилгаан эрчим хүчний хангамж билээ. Байшинд амьдарч байгаа өндөр настны өрхийн 96.6 хувь нь төвлөрсөн системд холбогдсон нь өмнөх тооллогоос 2.7 пунктээр нэмэгджээ. Төвлөрсөн системд холбогдсон өрхийн хувийн жин нэмэгдэж байгаа нь цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болсоныг харуулж байна.

Сүүлийн хоёр 10 тооллогоор хотын өрхүүд үндсэндээ цахилгаанаар хангагдсан, харин хөдөөгийн байшин сууцанд амьдардаг өрхийн хувьд нэлээд ялгаатай байна. 2020 онд хөдөөгийн өрхийн 16.4 хувь сэргээгдэх эрчим хүчний, 0.8 хувь дизель станц, бага оврын цахилгаан эх үүсвэр хэрэглэж, 0.1 хувь нь цахилгааны эх үүсвэргүй

байсан. Цахилгааны эх үүсвэргүй хөдөөгийн өрхийн эзлэх хувийн жин өмнөх тооллогоос 2.3 пунктээр буурсан байна.

### ХҮСНЭГТ 3. 7. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Ундны усны эх үүсвэр		Бүгд	Хот	Хөдөө
БҮГД		100.0	100.0	100.0
Сууцны доторх ундны усны эх үүсвэр	Бүгд	43.3	51.7	7.6
	Төвлөрсөн системд холбогдсон	42.9	51.5	6.9
	Бие даасан системээр холбосон	0.4	0.3	0.7
Сууцны гаднах ундны усны эх үүсвэр	Бүгд	56.7	48.3	92.4
	Хамгаалагдсан гүний худаг	32.5	25.7	61.1
	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон нийтийн ус түгээх байр	8.0	9.5	1.5
	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй нийтийн ус түгээх байр	5.6	6.4	2.0
	Хамгаалагдсан гар худаг	3.7	2.2	9.8
	Хамгаалагдсан булаг, шанд	0.1	0.0	0.6
	Хамгаалагдаагүй гүний худаг	0.4	0.3	1.2
	Хамгаалагдаагүй гар худаг	0.5	0.1	1.8
	Хамгаалагдаагүй булаг, шанд	0.1	0.0	0.4
	Зөөврийн усны үйлчилгээ	1.7	1.3	3.0
	Ердийн хөсгөөрх зөөврийн ус	0.2	0.1	0.2
	Савласан ус	2.0	2.3	0.9
	Хурын ус	0.0	0.0	0.0
	Усны ил эх үүсвэр (гол, мөрөн, нуур, тойром, цөөрөм)	1.9	0.1	9.8
	Бусад	0.1	0.1	0.0

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор өмнөх тооллогоос нарийвчлан тодорхойлж байгаа нэг үзүүлэлт бол ундны усны эх үүсвэр юм. Байшинд амьдардаг өрхийн ундны усны эх үүсвэр нь төвлөрсөн болон бие даасан системд холбогдсон бол байшин доторх, үүнээс бусад эх үүсвэрийг байшингийн гаднах эх үүсвэр гэж үзсэн. Энэ нь цэвэр усны хүрэлцээ, хангамж, ялангуяа түүний чанар нь хүний эрүүл мэнд, урт удаан наслахад нөлөөлөх гол үзүүлэлтүүдийн нэг билээ. Байшинд амьдардаг өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн 43.3 хувь нь сууцны доторх ундны усны эх үүсвэртэй бөгөөд үүний 99.2 хувь нь төвлөрсөн системээр ундны усны хэрэглээгээ хангаж байна.

Харин сууцны гаднах ундны усны эх үүсвэрээс ундны усаа хангадаг ахмадуудын 57.3 хувь нь хамгаалагдсан гүний худгаас, 23.9 хувь нь төвлөрсөн системд холбогдсон/холбогдоогүй нийтийн ус түгээх байруудаас ундны усаа авч байна. Мөн хөдөөгийн өрхийн дийлэнх буюу 92.4 хувь нь сууцны гаднах ундны усны эх үүсвэртэй бөгөөд үүний 61.1 хувь нь хамгаалагдсан гүний худгаас ундны усны хэрэглээгээ хангадаг байна. Өндөр настны өрхийн усан хангамжийг аймаг, нийслэлээр хавсралт 3.5(б)-ээс үзнэ үү.

ХҮСНЭГТ 3. 8. ӨНДӨР НАСТАН ГИШҮҮНТЭЙ, БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН  
 ХООЛ УНДАА БОЛГОДОГ ТҮЛШНИЙ ТӨРӨЛ, БАЙШИНГИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2020  
 ОН

Байшингийн төрөл	Бүгд	Цахилгаан	Мод	Сайжруулсан түлш	Нүүрс	Аргал, хөрсөн	Савласан хий	Бусад
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>63.4</b>	<b>14.5</b>	<b>9.5</b>	<b>8.3</b>	<b>3.2</b>	<b>1.1</b>	<b>0.1</b>
Орон сууцны байшин	100.0	99.8	0.0	0.0	0.1	0.0	0.1	0.0
Бие даасан тохилог сууц	100.0	95.8	0.4	0.0	0.0	0.0	3.8	0.0
Сууцны тусдаа байшин	100.0	35.0	25.9	16.7	14.7	5.6	1.7	0.2
Нийтийн байр	100.0	81.4	7.0	7.0	2.3	2.3	0.0	0.0
Нийтийн зориулалттай бусад байр	100.0	72.0	3.7	19.5	3.7	0.0	0.0	1.2

Өрхүүд хоол, хүнсээ бэлтгэхэд ямар түлш хэрэглэж байгаа нь өрхийн амьжиргаа, байгаль орчны эрүүл ахуйтай холбоотой чухал үзүүлэлт юм. Улсын дунджаар өндөр настан өрх хоол, хүнсээ бэлтгэхэд 10 өрхийн 6 нь цахилгаан, 3 нь мод, шахмал түлш, нүүрс хэрэглэж байна. Түлшний хэрэглээ, төрөл нь байшин сууцны төрлөөр ялгаатай байна. Ялангуяа сууцны тусдаа байшинд амьдардаг өрхийн 62.9 хувь нь мод, сайжруулсан түлш, нүүрс, аргал хөрсөн түлшийг хэрэглэдэг байна. Энэ нь сууцны тусдаа байшинд амьдардаг өндөр настнуудын 84.9 хувь нь ердийн галлагаагаар халаалтаа шийдсэн бөгөөд халаалтын эх үүсвэр нь хоол ундаа болгодог түлшний төрөлтэй шууд холбоотой байна. Хоол, хүнсээ бэлтгэхэд хэрэглэж байгаа түлшний байдал хот, хөдөөгөөр нэлээд ялгаатай байна. Хотын өрх цахилгаан болон нүүрс, шахмал түлшийг голдуу хэрэглэдэг бол хөдөөний өрхийн үндсэн түлш нь мод, түлээ, аргал, хөрсөн байна. Өндөр настны өрхийн хоол ундаа болгодог түлшний төрлийг хот, хөдөөгөөр хавсралт 3.7-оос үзнэ үү.

ХҮСНЭГТ 3. 9. ГЭРТ АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТНЫ ӨРХИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТООГООР, 2010, 2020

Ханын тоо	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
2010						
<b>БҮГД</b>	<b>44 821</b>	<b>100.0</b>	<b>20 525</b>	<b>100.0</b>	<b>24 296</b>	<b>100.0</b>
5 хүртэл	14 526	32.4	6 793	33.1	7 733	31.8
5	22 988	51.3	11 311	55.1	11 677	48.1
6	6 507	14.5	2 091	10.2	4 416	18.2
8	796	1.8	327	1.6	469	1.9
10	4	-	3	-	1	-
2020						
<b>БҮГД</b>	<b>55 298</b>	<b>100.0</b>	<b>23 544</b>	<b>100.0</b>	<b>31 754</b>	<b>100.0</b>
5 хүртэл	11 314	20.5	4 045	17.2	7 269	22.9
5	36 607	66.2	16 846	71.6	19 761	62.2
6	6 216	11.2	2 071	8.8	4 145	13.1
8	1 118	2.0	549	2.3	569	1.8
10	43	0.1	33	0.1	10	0.0

Монголын уламжлалт сууц болох гэр нь бүтэц хийц, ахуйн нөхцлийн хувьд үндэсний онцлогтой. Гэрийн талбайн хэмжээ нь түүний ханын тооноос хамаарна. Өрхийн амьжиргааны түвшинг илэрхийлэх үзүүлэлтийн нэг бол гэрийн ханын тоо юм.

Өмнөх тооллогын дүнгээр гэрт амьдардаг өндөр настан өрхийн 1/3 нь 5 хүртэлх ханатай гэрт, 2 өрхийн нэг нь 5 ханатай гэрт амьдарч байсан бол 2020 онд гэрт амьдардаг өрхийн 1/5 нь 5 хүртэлх тооны ханатай, 66.2 хувь нь 5 ханатай гэрт, 11.2 хувь нь 6 ханатай гэрт амьдарч байгаа нь өрхийн амьжиргаа, амьдралын тухтай орчин дээшилснийг харуулж байна. Хотын өрхийн 80 хувь, хөдөөгийн өрхийн 70 гаруй хувь нь 5-6 ханатай гэрт амьдарч байгаа нь хот, хөдөөгийн хувьд онцын ялгаагүй байна.

ХҮСНЭГТ 3. 10. ГЭРТ АМЬДАРДАГ ӨНДӨР НАСТАН ӨРХИЙН АХУЙН НӨХЦЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

		Бүгд	Хот	Хөдөө
<b>БҮГД</b>		<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Хатуу хог, хаягдал зайлуулалт	Үйлчилгээний байгууллагаар	44.7	88.8	12.0
	Зөвшөөрөгдсөн цэгт	17.5	6.1	26.1
	Шатаадаг	2.7	0.2	4.5
	Булдаг	0.3	0.0	0.5
	Тогтсон цэг байхгүй	34.8	4.9	56.9
<b>БҮГД</b>		<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Бие засах газар	Сайжруулсан нүхэн жорлон	1.3	1.9	0.8
	Энгийн нүхэн жорлон	80.1	97.0	67.6
	Био жорлон	0.1	0.2	0.1
	Задгай	18.4	0.8	31.5
<b>БҮГД</b>		<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Бохир ус зайлуулалт	Цооног	55.6	85.4	33.5
	Задгай	44.4	14.6	66.5

Өрхийн хатуу, хог хаягдлыг нэгдсэн бодлогоор ангилан ялгаж, тогтсон газар зайлуулах, бохир усыг нэгдсэн шугам сүлжээгээр зайлуулж, цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэх нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, хөрсний бохирдолд ихээхэн нөлөөтэй. Ялангуяа, хүн ам ихээр төвлөрсөн томоохон төв, суурин газруудад хатуу хог, хаягдлыг дахин боловсруулах, иргэдэд хогоо ялгаж зайлуулах ухамсрыг төлөвшүүлэх зэрэг олон асуудалд энэхүү үзүүлэлтүүд тодорхой хариулт өгнө. Гэрт амьдардаг өрхийн 44.7 хувь нь үйлчилгээний байгууллагаар, 34.8 хувь нь хог хаягдлаа зайлуулж байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор өрхийн бие засах газрын төрлийг асуугаагүй тул 2020 оны тооллоготой харьцуулах боломжгүй юм. Гэрт амьдардаг өрхийн 80.1 хувь энгийн нүхэн жорлонд бие засаж байна. Хотод 97.0 хувь нь энгийн нүхэн жорлонтой байгаа бол хөдөөд 31.5 хувь нь тогтсон газаргүй байна. Харин гэрт амьдардаг өндөр настны өрхийн 55.6 хувь нь цооногт бохир усаа зайлуулж байна. Энэ үзүүлэлтийг хот, хөдөөгөөр авч үзвэл хотод амьдардаг өрхийн 85.4 хувь нь цооногт бохир усаа зайлуулж байхад хөдөөд 66.5 хувь задгай асгаж байна. Гэрт амьдардаг өндөр настан өрхийн тэргүүлэгчтэй өрхийн ахуйн нөхцлийн аймаг, нийслэлээрх үзүүлэлтүүдийг хавсралт 3.10-3.11-ээс үзнэ үү.

4

БҮЛЭГ

# ӨНДӨР НАСТНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### 4.1. ӨНДӨР НАСТНЫ ҮНДЭС, УГСАА


Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 99.3 хувь, үүнээс өндөр настны 99.2 хувь Монгол Улсын харьяат байна. Монгол Улсын харьяат иргэдийн үндэс, угсааны талаарх мэдээллийг өмнөх тооллогод 29 бүлгээр цуглуулж байсныг Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор 31 болгож өргөжүүлсэн. Монгол Улсын харьяат хүн амын 83.8 хувийг, өндөр настны 82.8 хувийг Халх, 10 орчим хувийг Казах, Дөрвөд, Буриад, Баяд угсаатан эзэлж байна. Өмнөх тооллогын үеийнхээс Халхуудын эзлэх хувь 2.5 пунктээр өсжээ.

ХҮСНЭГТ 4. 1. НИЙТ ХҮН АМ, ӨНДӨР НАСТАН ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, ҮНДЭС, УГСАА, ХҮЙСЭЭР, , 2000, 2010, 2020 ОН

Үндэс угсаа	2010				2020			
	Нийт хүн ам	Үүнээс: Өндөр настан	Үүнд		Нийт хүн ам	Үүнээс: Өндөр настан	Үүнд	
			Эрэгтэй	Эмэгтэй			Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Монгол Улсын харьяат	99.4	99.5	99.3	99.6	99.3	99.2	98.8	99.5
Халх	82.6	80.3	79.7	80.8	83.8	82.8	82.4	83.1
Казах	3.8	3.3	3.7	2.9	3.8	3.0	3.3	2.7
Дөрвөд	2.7	2.8	2.7	2.8	2.6	2.7	2.6	2.7
Буриад	1.7	2.5	2.5	2.5	1.4	2.2	2.1	2.2
Баяд	2.1	2.3	2.3	2.3	2.0	2.2	2.3	2.2
Бусад	7.1	8.9	9.2	8.7	6.4	7.1	7.3	7.1
Гадаадын харьяат, харяалалгүй	0.6	0.5	0.7	0.4	0.7	0.8	1.2	0.5

Өндөр настны дунд эмэгтэйчүүдийн дундаж нас өндөр байдгийг судалгааны 2-р бүлэгт тайлбарласан. Энэ хандлага Казахаас бусад угсаатны хувьд ижил байна. Казахуудаас бусад угсаатны хүйсийн харьцаа ерөнхийдөө бага байна.

ЗУРАГ 4. 1. ӨНДӨР НАСТНЫ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ҮНДЭС УГСАА, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН





Өндөр настан Казахуудын хүйсийн харьцаа улсын хэмжээний өндөр настан, бусад үндэс, угсаатнаас нэлээд өндөр байгаа нь онцлог юм.

#### ХҮСНЭГТ 4. 2. ӨНДӨР НАСТНЫ ҮНДЭС, УГСАА, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Үндэс, угсаа	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>95 074</b>	<b>100.0</b>	<b>137 023</b>	<b>100.0</b>	<b>232 097</b>
Монгол Улсын харъяат	100.0	93 899	100.0	136 305	100.0	230 204
Үүнээс: үндэс, угсаагаар						
Халх	100.0	77 418	100.0	113 203	100.0	190 621
Казах	100.0	3 097	100.0	3 741	100.0	6 838
Дөрвөд	100.0	2 427	100.0	3 744	100.0	6 171
Буриад	100.0	1 962	100.0	3 030	100.0	4 992
Баяд	100.0	2 184	100.0	2 983	100.0	5 167
Бусад	100.0	6 811	100.0	9 604	100.0	16 415
Гадаадын харъяат, харьяалалгүй	100.0	1 175	100.0	718	100.0	1 893

Улсын дунджаар өндөр настан хүн амын 9.7 хувийг 80, түүнээс дээш насныхан эзэлж байхад Казах, Буриадынх 10.6-10.7 хувь, Халхуудынх 9.6 хувь байгаа нь бусадтай харьцуулахад арай илүү урт насалж байгааг харуулна. Өндөр настан нийт эмэгтэйчүүдийн дунд 80, түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийг эрэгтэйчүүдтэй харьцуулахад Халх 2.7 пункт, Казах 1.7 пункт, Дөрвөд 3.4 пункт, Буриад 4.1 пункт, Баяд 3.9 пунктээр илүү байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс урт насалдаг болохыг харуулж байна.

#### ХҮСНЭГТ 4. 3. ӨНДӨР НАСТНЫ ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Өндөр настан хүн ам		Шүтдэггүй	Шашинтан				
	Бүгд	Хувь		Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
2010								
<b>БҮГД</b>	<b>151 159</b>	<b>100.0</b>	<b>25.3</b>	<b>68.2</b>	<b>1.5</b>	<b>3.2</b>	<b>1.4</b>	<b>0.4</b>
60-64	49 453	100.0	27.9	65.2	1.9	2.9	1.7	0.4
65-69	38 232	100.0	27.1	66.4	1.7	2.9	1.4	0.4
70-74	29 332	100.0	26.3	67.4	1.5	3.3	1.2	0.5
75-79	18 617	100.0	23.5	70.3	1.3	3.2	1.3	0.4
80+	15 525	100.0	19.1	74.8	1.0	3.8	1.0	0.4
2020								
<b>БҮГД</b>	<b>232 029</b>	<b>100.0</b>	<b>27.4</b>	<b>66.3</b>	<b>1.5</b>	<b>2.6</b>	<b>1.6</b>	<b>0.5</b>
60-64	96 433	100.0	30.0	63.7	1.5	2.4	1.9	0.5
65-69	55 279	100.0	28.0	65.8	1.5	2.5	1.6	0.6
70-74	32 748	100.0	25.2	68.7	1.8	2.4	1.5	0.5
75-79	25 113	100.0	23.9	69.8	1.6	2.8	1.2	0.7
80+	22 456	100.0	22.0	71.8	1.3	3.4	1.2	0.4

Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн “Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” гэсэн 3 дугаар бүлгийн 1 дэх хэсэгт “Аливаа шашныг

шүтэх, эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна” гэж заасан. Хүн ам, орон сууцны тооллогод “Та шашин шүтдэг үү, шүтдэг бол ямар шашин шүтдэг вэ?” гэсэн асуултыг ээлжит тооллогод хүн амын 10 хувийн түүвэрт сонгогдсон 15, түүнээс дээш насны хүн амаас асуусан. Нийт өндөр настны 72.6 хувь нь шашин шүтдэгээс 66.3 хувь нь будда, 2.6 хувь нь ислам, 1.5 хувь нь бөө, 1.5 хувь нь христийн шашин шүтэж байна. Харин нийт өндөр настны 27.4 хувь нь шашин шүтдэггүй байна. Шашин шүтлэгийг өндөр настны насны бүлгээр авч үзэхэд онцын ялгаа байхгүй байна.

## 4.2. ӨНДӨР НАСТНЫ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Монгол Улс 1924 оноос иргэнээ үнэ, төлбөргүйгээр сурч боловсрохыг үндсэн хуулиараа баталгаажуулсан нь өнөөгийн өндөр настнуудын бичигтэн болох, боловсрол эзэмших бодит боломжийг олгосон юм. Хүн амын бичиг үсэгт тайлагдах, боловсрол эзэмших боломж, нөхцөл нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн үе шатаас хамаарч, харилцан адилгүй байсныг энэ бүлэгт харуулна. Аль нэг хэлээр (бичгийн төрөл хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзсэн. Мөн ямар нэг түвшний боловсролтой хүн амыг бичиг үсэг мэддэг гэж үзсэн бөгөөд боловсролгүй хүн амаас бичиг үсэг мэддэг эсэхийг тодруулсан. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолмол аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн гишүүдээс бичиг үсэг тайлагдалтын талаарх мэдээллийг авсан. Тиймээс 2020 оны тооллогын бичиг үсэг тайлагдалтын талаарх тоон мэдээллийг 2010 оны тооллогын дүнтэй хувийн жингээр харьцуулсан болно.

### ХҮСНЭГТ 4. 4. ӨНДӨР НАСТНЫ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин	2010			2020		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	7.7	14.8	11.8	2.1	3.4	2.9
Бичиг үсэг мэддэггүй	2.1	5.6	4.1	0.6	1.3	1.0
Бичиг үсэг мэддэг	5.6	9.2	7.7	1.5	2.1	1.9
Боловсролтой	92.3	85.2	88.2	97.8	96.6	97.0
Бага	24.7	35.1	30.6	14.3	20.6	18.0
Бүрэн бус дунд*	13.0	10.3	11.5	18.1	14.8	16.1
Бүрэн дунд ТМС**	19.4	16.8	17.9	30.1	25.2	27.2
ТМД бүрэн бус дээд***	10.4	11.5	11.0	10.0	14.6	12.7
Дээд	24.8	11.5	17.2	25.3	21.4	23.0

\*суурь боловсролтой хүн ам

\*\* бүрэн дунд, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн ам

\*\*\*тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн ам

Боловсрол эзэмшигчдийн хүйсийн ялгаатай байдал харьцангуй багасаж байгаа тал ажиглагдаж байна. Ялангуяа өмнөх тооллогоор дээд боловсролтой эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдийнхээс 13.3 пунктээр илүү байсан бол 2020 онд тус зөрүү 3.9 пункт болж буурчээ. Улсын хэмжээнд дээд боловсролтой хүн амын эзлэх

хувь эрэгтэйчүүдийг бодвол эмэгтэйчүүдийнх өндөр байдаг бол өндөр настны хувьд энэ нь эсрэгээрээ байна. Мөн боловсролгүй хүн амын эзлэх хувь өмнөх тооллогын дүнгээс 8.9 пунктээр буурсан бол суурь, бүрэн дунд, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амын эзлэх хувь 13.9 пунктээр нэмэгдсэн нь манай улсын боловсролын салбарын хөгжлийн ололт, төр, засгаас хүн амын боловсролыг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд онцгой анхаарч байсны үр дүн юм. Мэргэжлийн боловсон хүчнийг 1950-иад оноос эхлэн хилийн чанадад бэлтгэж, улмаар 1960-аад оноос мэргэжлийн дунд болон дээд боловсролтой боловсон хүчнийг дотооддоо олноор бэлтгэх болсонтой холбоотой их, дээд болон мэргэжлийн дунд шатны сургуульд суралцагчдын тоо нэмэгдэж байсан 1960-1980-аад онд 10-25 орчим настай байсан иргэд одоо өндөр настны эгнээг тэлж байгаа нь өндөр настны боловсролын бүтцийг өөрчлөгдөхөд нөлөөлжээ.

#### ХҮСНЭГТ 4. 5. ӨНДӨР НАСТНЫ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>			
БҮГД	100.0	100.0	100.0
Боловсролгүй	2.9	2.1	3.4
Бичиг үсэг мэддэг	1.9	1.5	2.1
Бичиг үсэг мэддэггүй	1.0	0.6	1.3
Боловсролтой	97.0	97.9	96.6
Бага	18.0	14.3	20.6
Суурь	16.1	18.1	14.8
Бүрэн дунд	22.5	24.3	21.2
Техник болон мэргэжлийн	4.7	5.8	4.0
Тусгай мэргэжлийн дунд	12.7	10.0	14.6
Дээд	23.0	25.4	21.4
<b>ХОТ</b>			
БҮГД	100.0	100.0	100.0
Боловсролгүй	1.8	1.2	2.2
Бичиг үсэг мэддэг	1.2	0.9	1.4
Бичиг үсэг мэддэггүй	0.6	0.3	0.8
Боловсролтой	98.1	98.9	97.7
Бага	9.0	6.2	10.9
Суурь	11.8	12.8	11.2
Бүрэн дунд	27.8	29.9	26.4
Техник болон мэргэжлийн	4.8	5.3	4.4
Тусгай мэргэжлийн дунд	14.6	11.1	17.0
Дээд	30.1	33.6	27.8
<b>ХӨДӨӨ</b>			
БҮГД	100.0	100.0	100.0
Боловсролгүй	5.2	3.8	6.2
Бичиг үсэг мэддэг	3.3	2.7	3.8
Бичиг үсэг мэддэггүй	1.9	1.1	2.4
Боловсролтой	94.8	96.2	93.6
Бага	37.6	31.1	42.3
Суурь	25.6	29.2	22.9
Бүрэн дунд	10.9	12.9	9.4
Техник болон мэргэжлийн	4.6	6.8	3.0
Тусгай мэргэжлийн дунд	8.5	7.8	9.1
Дээд	7.6	8.4	6.9

Улсын хэмжээнд өндөр настны 99.0 хувь нь үүнээс эрэгтэйчүүдийн 99.4 хувь, эмэгтэйчүүдийн 98.7 хувь бичиг үсэг мэддэг байна. Өндөр настны бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин тэдний байршил, насны бүлгээр нэлээд өөр байна. Өндөр настны насны бүлэг ахих тутам бичиг үсэг үл мэдэгчид, бага, техник болон мэргэжлийн боловсролтой хүний эзлэх хувь өсөж, суурь болон магистрын боловсролтой өндөр настны эзлэх хувь буурч байгааг харуулж байна.

Насны бүлэг ахих тусам бичиг үсэг мэддэггүй өндөр настан эрэгтэй болон эмэгтэйчүүдийн эзлэх хувь ялгаатай болж байна. Өндөр настай эрэгтэй, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин насны бүлгээр ялгаатай байгаа нь тэдний боловсрол, мэргэжил эзэмшиж байсан үетэй холбоотой.

Мөн өндөр настнуудыг байршлаар авч үзэхэд хөдөөгийн өндөр настнуудын хувьд дийлэнх нь бага болон суурь боловсролтой байхад хотын өндөр настнуудын дийлэнх нь бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой байна. Энэ нь өндөр настны боловсрол, ажил, суурьшил, өмчийн ялгаатай байдал зэргээс хамаарахын зэрэгцээ, ялангуяа хөдөөд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх боломж түүнчлэн цалин, хөлсний тогтолцоо, үйлдвэрлэл, байршил зэрэг олон зүйлээс хамаарч мэргэжил, боловсролтой өндөр настан төв суурин газарт шилжин суурьших нь илүү байгаагай холбоотой. Өндөр настны бичиг үсгийн мэдлэг, боловсролын байдлыг аймаг, нийслэлээр, хүйс, байршлаар хавсралт 4.3-4.4-т үзүүлэв.

### 4.3. ӨНДӨР НАСТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хүн амын эдийн засгийн талаарх мэдээлэл нь тухайн улс орны эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн хэв маяг, зах зээлийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн цар хүрээ зэргийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Мөн хүн ам, орон сууцны тооллогын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг засаг захиргааны хамгийн бага нэгжийн түвшинд гаргах боломжтойгоороо бусад төрлийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаануудаас давуу талтай.

“Хөдөлмөрийн тухай” Монгол Улсын хуулиар ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тохиолдолд ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлах боломжтой бөгөөд тэтгэвэр авагч ахмад настан хөдөлмөр эрхэлж болно гэж заажээ. Харин “Төрийн албаны тухай” хуулийн 41.2-т Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 нас байна гэж заасан байна.

Ажиллах хүчинд ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүй иргэдийг хамруулсан нь цаашдаа улс орны нийгэм, эдийн засаг ялангуяа ажиллах хүчний бодлого боловсруулахад суурь мэдээлэл болдог. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлээгүй хүмүүсээс гадна тохирох ажил олдохгүй байгаагийн улмаас хөдөлмөр эрхлээгүй хүнийг оруулсан.

ХҮСНЭГТ 4. 6. ӨНДӨР НАСТНЫ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

	Хот			Хөдөө			Бүгд		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
2010									
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Ажиллах хүч	13.1	4.8	8.4	19.3	7.8	11.2	13.1	4.8	8.4
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	86.9	95.2	91.6	80.7	92.2	88.8	86.9	95.2	0.9
2020									
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Ажиллах хүч	17.7	7.9	11.8	40.3	17.9	27.4	25.0	10.9	16.7
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	82.3	92.1	88.2	59.7	82.1	72.6	75.0	89.1	83.3

Нийт өндөр настнуудын 16.7 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 8.3 пунктээр өсжээ. Ажиллах хүчний оролцооны түвшнийг байршил, хүйсээр ангилахад нэлээд ялгаатай байна. Тооллогын дүнгээр хөдөөгийн малчин өрхийн хүмүүсийг ажил эрхэлдэг гэж үздэгээс хамаарч, хөдөөгийн ажиллах хүчний оролцооны түвшин хотоос өндөр гарахад нөлөөлсөн байх талтай юм. Хөдөөгийн өндөр настны ажиллах хүчний оролцооны түвшин 2010 оны тооллогын үеийнхээс 16.2 пунктээр өсжээ. Энэ нь Монгол Улсын хувьд хөдөө аж ахуйн салбарт ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэлд өндөр настан оролцох өргөн боломжтой байдагтай холбоотой. Гэхдээ хуулийн зохицуулалтаар өндөр настны ажиллах эрх зүйн орчинг хязгаарласан байдаг. Ялангуяа 65 хүртэлх насны хүн амын боловсрол, мэргэжил, ажлын дадлага, туршлага зэргийг харгалзан тэднийг ажиллах нөхцөл боломжоор хангах, нийгэм, эдийн засгийн тухайн үеийн төрийн бодлогоор бэлтгэгдсэн энэхүү үнэт нөөцийг цаг алдалгүй бүрэн ашиглах талаар төр, засаг болон аж ахуйн нэгж, байгууллагууд нэгдмэл бодлоготой ажиллах нь чухал юм. Цаашид нарийн мэргэжлийн мэргэшсэн, өндөр боловсролтой, түүнчлэн эрдэмтэн доктороор тэдний эгнээ өргөжих тул оюуны болон мэргэжлийн туршлага, чадавхийг ашиглах системтэй тогтолцоог бий болгох нь нийгэмд ч хувь хүндээ ч эерэг үр дүнг авчирна. Үүний тулд тэднийг ажиллуулах таатай нөхцлийг бүрдүүлсэн хууль эрх зүйн орчинг шинэчлэх асуудал хүн ам цөөтэй, хүний нөөц хязгаарлагдмал Монгол Улсын анхааран шийдвэрлэх шаардлагыг бий болгож байна. Өндөр настны эдийн засгийн идэвх, нас, хүйс, хот, хөдөөгөөр нэлээд ялгаатай байгааг дараах хүснэгтээс харж болно.

ХҮСНЭГТ 4. 7. ӨНДӨР НАСТНЫ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>			
БҮГД	100.0	100.0	100.0
Ажиллах хүч	16.7	25.0	10.9
Ажилтай	16.4	24.4	10.8
Ажилгүй	0.4	0.6	0.2
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	83.3	75.0	89.1
Сургуульд сурдаг	0.0	0.0	0.0
Тэтгэвэрт	79.7	69.1	87.1
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	1.4	2.4	0.7
Гэрийн ажилтай	0.5	0.5	0.5
Тохирох ажил олдохгүй байгаа	0.8	1.6	0.2
Ажиллах сонирхолгүй	0.0	0.1	0.0
Бусад	0.8	1.2	0.4
<b>ХОТ</b>			
БҮГД	100.0	100.0	100.0
Ажиллах хүч	11.8	17.7	7.9
Ажилтай	11.4	17.0	7.7
Ажилгүй	0.4	0.7	0.2
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	88.2	82.3	92.1
Сургуульд сурдаг	0.1	0.1	0.1
Тэтгэвэрт	84.4	75.9	90.1
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	1.5	2.7	0.7
Гэрийн ажилтай	0.5	0.6	0.5
Тохирох ажил олдохгүй байгаа	0.9	1.7	0.3
Ажиллах сонирхолгүй	0.0	0.1	0.0
Бусад	0.8	1.3	0.5
<b>ХӨДӨӨ</b>			
БҮГД	100.0	100.0	100.0
Ажиллах хүч	27.4	40.3	17.9
Ажилтай	27.1	39.8	17.8
Ажилгүй	0.3	0.5	0.1
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	72.6	59.7	82.1
Сургуульд сурдаг	0.0	0.0	0.0
Тэтгэвэрт	69.5	54.9	80.4
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	1.1	1.8	0.6
Гэрийн ажилтай	0.5	0.5	0.5
Тохирох ажил олдохгүй байгаа	0.6	1.3	0.2
Ажиллах сонирхолгүй	0.1	0.1	0.0
Бусад	0.7	1.1	0.4

Нийт өндөр настны дунд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь нас ахих тутам буурч байгаа нь тэдний хөдөлмөрлөх чадвар буурдагтай холбоотой. Залуу насандаа эх орныхоо хөгжилд оруулсан хувь нэмрийг нь бодитоор үнэлж, тэднийг сэтгэл түвшин, хангалуун амьдрах нөхцлийг хангахуйц нийгмийн даатгалын тогтолцоо, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд онцгой анхаарах нь зүйтэй байна.

Өндөр настай эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвх эрэгтэйчүүдээс нэлээд доогуур байгаа нь “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай” Монгол Улсын хуульд даатгуулагч 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, 55 нас хүрсэн, төрүүлсэн болон 3 хүртэл настайд үрчлэн авсан 4 түүнээс дээш хүүхэдтэй, отгон хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, 50 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй” гэсэн заалттай уялдан эмэгтэйчүүд эрт тэтгэвэрт гардагтай холбоотой. Ингэж эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвх доогуур байгаа нь тэдний амьжиргаанд сөргөөр нөлөөлж ялангуяа эрүүл мэнд доройтойх, ядууралд өртөх магадлал өндөр болно.

#### ХҮСНЭГТ 4. 8. АЖИЛ ЭРХЭЛДЭГ ӨНДӨР НАСТАН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010									
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
60-64	58.3	57.4	60.2	64.0	61.9	68.5	52.5	52.6	52.3
65-69	25.5	26.0	24.4	23.8	24.7	21.9	27.2	27.4	26.8
70-74	11.0	11.5	10.1	8.7	9.6	6.8	13.4	13.6	13.1
75-79	4.0	4.1	3.9	2.8	3.1	2.1	5.3	5.1	5.7
80+	1.1	1.0	1.4	0.7	0.7	0.6	1.6	1.3	2.1
2020									
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
60-64	62.2	62.1	62.4	65.3	63.9	67.4	59.3	60.4	57.4
65-69	21.7	21.8	21.4	21.0	21.0	20.8	22.3	22.5	22.0
70-74	8.5	8.7	8.1	8.1	9.1	6.6	8.8	8.4	9.5
75-79	4.9	5.0	4.7	3.8	4.3	3.0	5.9	5.6	6.4
80+	2.8	2.4	3.4	1.8	1.6	2.1	3.7	3.0	4.7

Ажил эрхэлж буй өндөр настны 62.2 хувь нь 60-64 насныхан бөгөөд өмнөх тооллогын дүнгээс 3.9 пунктээр өссөн байна. Өндөр настны хөдөлмөр эрхлэлтийн байдал хот, хөдөөд төстэй байна. Ажил эрхэлдэг өндөр настны байдлыг нас бүлэг, хот, хөдөө, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, боловсролын түвшнээр хавсралт 4.6, 4.8, 4.9, 4.10, 4.11-ээс үзнэ үү.

ХҮСНЭГТ 4. 9. АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ӨНДӨР НАСТАН, АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Ажил мэргэжил	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>			
БҮГД	100.0	100.0	100.0
Менежер	9.2	8.9	9.8
Мэргэжилтэн	17.0	14.0	21.6
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	1.8	1.9	1.7
Контор, үйлчилгээний ажилтан	2.2	1.9	2.7
Худалдаа, үйлчилгээний ажилтан	5.6	5.1	6.2
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	50.2	51.6	47.9
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	3.3	3.6	2.9
Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч	3.4	5.2	0.4
Энгийн ажил, мэргэжил	7.0	7.3	6.5
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	0.4	0.5	0.4
<b>ХОТ</b>			
БҮГД	100.0	100.0	100.0
Менежер	17.2	16.7	18.1
Мэргэжилтэн	32.3	27.2	39.9
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	3.1	3.2	2.9
Контор, үйлчилгээний ажилтан	4.0	3.4	5.0
Худалдаа, үйлчилгээний ажилтан	9.6	9.4	9.8
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	9.7	11.3	7.3
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	5.1	5.8	4.1
Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч	5.7	9.0	0.7
Энгийн ажил, мэргэжил	12.5	13.0	11.6
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	0.8	0.9	0.7
<b>ХӨДӨӨ</b>			
БҮГД	100.0	100.0	100.0
Менежер	1.8	1.9	1.6
Мэргэжилтэн	2.7	2.3	3.4
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	0.7	0.8	0.5
Контор, үйлчилгээний ажилтан	0.5	0.5	0.4
Худалдаа, үйлчилгээний ажилтан	1.8	1.4	2.6
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	87.7	87.4	88.2
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	1.6	1.5	1.7
Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч	1.2	1.9	0.2
Энгийн ажил, мэргэжил	1.9	2.2	1.4
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	0.0	0.1	0.0

Мэргэжилтэй, ажлын дадлага, туршлагатай өндөр настанг удирдлага, үйлдвэрлэл, үйлчилгээнд тэдний өөрсдийнх нь идэвх, санаачлагыг боломжит дээд хэмжээгээр ашиглах нь зүйтэй юм. Ажил эрхэлж буй өндөр настныг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл хотод ажил эрхэлж байгаа өндөр настнууд мэргэжилтэн, менежер, энгийн ажил, мэргэжил орж байна. Мөн хөдөөд ажил эрхэлж байгаа өндөр



